

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр, Мягмар гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 11
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	12 – 57
1.	<i>Байнгын хорооны 2025 оны 04 дүгээр тогтоолоор байгуулагдсан Сонгон шалгаруулах комиссын тайлан</i>	13 – 21
2.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/</i>	21 – 26
3.	<i>Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал</i>	26 – 27
4.	<i>“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./</i>	27 – 51
5.	<i>Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.05.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	52 – 54
6.	<i>Бусад. “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол</i>	54 – 57

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 05 дугаар сарын 20-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 36 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Бат-Эрдэнэ, Б.Пүрэвдорж, Ц.Туваан, О.Цогтгэрэл, Ө.Шижир;

Чөлөөтэй: С.Амарсайхан, Л.Гантөмөр, Л.Мөнхбаатар, Л.Оюун-Эрдэнэ, Н.Учрал, Э.Одбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: Т.Доржханд.

Нэг.Байнгын хорооны 2025 оны 04 дүгээр тогтоолоор байгуулагдсан Сонгон шалгаруулах комиссын тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга В.Жавзан, Жендэрийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Т.Энхбаяр, Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Т.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Байнгын хороодын ажлын албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Тайланг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Э.Болормаа нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны 2025 оны 04 дүгээр тогтоолоор байгуулагдсан Сонгон шалгаруулах комиссын тайланг сонсов.

Уг асуудлыг 11 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Байнгын хороодын ажлын албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Байнгын хорооны тогтоолын төслийг хуралдаан даргалагч Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, Б.Баярбаатар, О.Алтангэрэл нар үг хэлэв.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийг сонсгол даргалагчаар сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 7
Бүгд: 13
46.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг санал хураалтыг хүчингүй болгож, санал хураалтыг дахин явуулъя гэсэн горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 8
Бүгд: 13
38.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

“Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хойшлуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Байнгын хороодын ажлын албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төсөл бүрээр санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ц.Сандаг-Очир: Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ц.Сандаг-Очир: Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Уг асуудлыг 12 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Д.Баяндүүрэн, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга Д.Ариунболд, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга В.Жавзан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Энх-Амгалан, Хөгжлийн хэлтсийн Төслийн бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Балчинлуvsан, Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын ахлах мэргэжилтэн З.Райынбек, мөн яамны Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Отгонцэцэг, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн шинжээч Т.Хонгор нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Л.Батмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Байнгын хороодын ажлын албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, С.Зулпхар, Э.Болормаа, Ж.Баярмаа, Г.Уянгахишиг, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Д.Баяндүүрэн, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга В.Жавзан нар хариулж, тайлбар хийв.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан, 1.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого гэсэн 4 дүгээр тэргүүлэх чиглэлд доор дурдсан агуулгатай 4.1.5, 4.1.6 дахь заалтыг тус тус нэмэх:

“4.1.5.даргын эрх мэдлийг баталгаажуулсан байгууллагын хуулийг өөрчилж, иргэнд үйлчлэх албаны хууль болгон шинэчлэх ажлыг эрчимжүүлнэ;

4.1.6.төрийн албан хаагчийн улс төрийн болон удирдлагын хууль бус шийдвэр, аливаа дарамт шахалтаас ангид байлгах эрх зүйн шинэчлэл хийнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 8
Бүгд: 13
38.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 8
Бүгд: 13
38.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Ц.Сандаг-Очир: 2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого гэсэн 4 дүгээр тэргүүлэх чиглэлд доор дурдсан агуулгатай 4.4.4 дэх заалтыг нэмэх:

“4.4.4.төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйлдлээс хохирсон иргэд, бизнес эрхлэгчдийн хохирлыг шуурхай барагдуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13

53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэлийн гаргасан горимын саналаар дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13

53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан, 1.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого гэсэн 4 дүгээр тэргүүлэх чиглэлд доор дурдсан агуулгатай 4.1.5, 4.1.6 дахь заалтыг тус тус нэмэх:

“4.1.5.даргын эрх мэдлийг баталгаажуулсан байгууллагын хуулийг өөрчилж, иргэнд үйлчлэх албаны хууль болгон шинэчлэх ажлыг эрчимжүүлнэ;

4.1.6.төрийн албан хаагчийн улс төрийн болон удирдлагын хууль бус шийдвэр, аливаа дарамт шахалтаас ангид байлгах эрх зүйн шинэчлэл хийнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13

53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.05.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Бүс, орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын дарга П.Зоригтбаатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Байнгын хороодын ажлын албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

-“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1

дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах гэсэн горимын санал гаргав.

Л.Энх-Амгалан: Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	5
Бүгд:	13

61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Бусад.“Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Байнгын хороодын ажлын албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх хүсэлтийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн тавьсан асуултад хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн. Ц.Сандаг-Очир хариулж, тайлбар хийв.

Ц.Сандаг-Очир: Дагвадоржийн Дэлгэрсайханыг өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 7
Бүгд: 13
46.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 7
Бүгд: 13
46.2 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ц.Сандаг-Очир: Дагвадоржийн Дэлгэрсайханыг өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооноос чөлөөлөхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4

Бүгд: 13

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 52 минут үргэлжилж, 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 28 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
11 цаг 36 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан эхэлж байна.

Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Оюунсайханы Алтангэрэл, Дашзэвэгийн Амарбаясгалан, Батын Батбаатар, Баярмагнайн Баярбаатар, Жудагийн Баярмаа, Энхбатын Болормаа, Сандагийн Бямбацогт, Сархадын Зулпхар, Одсүрэнгийн Номинчимэг, Нямтайширын Номтойбаяр, Цэндийн Сандаг-Очир, Гончигдоржийн Уянгахишиг, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж ирц бүрдсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Байнгын хорооны 2025 оны 04 дүгээр тогтоолоор байгуулагдсан Сонгон шалгаруулах комиссын тайланг хэлэлцэнэ.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл. Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай хоёр дахь асуудал байна.

Гурав.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Дөрөв.“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Засгийн газар 2025 оны 04 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хоёр дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ.

Тав.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль. /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүд. Засгийн газар 2025 оны 05 сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

“Бусад” гэсэн ийм 6 асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/ Хэлэлцэх асуудал батлагдлаа.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Байнгын хорооны 2025 оны 04 дүгээр тогтоолоор байгуулагдсан
Сонгон шалгаруулах комиссын тайлан**

Нэг.Байнгын хорооны 2025 оны 04 дүгээр тогтоолоор байгуулагдсан сонгон шалгаруулах комиссын тайланг хэлэлцэнэ.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Сонгон шалгаруулах комиссын даргаар Б.Хатантуул Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх.

Комиссын гишүүд Ц.Наранчимэг Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор, В.Жавзан Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга, Т.Энхбаяр Жендэрийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга, Т.Энхболд Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар.

Нэр бүхий ажлын хэсгүүдийг танилцууллаа.

Ингээд хэддүгээр микрофон вэ? 5 дугаар микрофон дээр микрофоныг өгье. Ажлын хэсгийн тайланг ажлын хэсгийн ахлагч Б.Хатантуул.

Б.Хатантуул: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Сонгон шалгаруулалт комиссын тайлангийн танилцуулгыг Та бүхэнд танилцуулъя.

Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр

дэвшүүлэх, төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах үүрэг бүхий комиссыг Төрийн байгуулалтын байнгын хорооны 2018 оны 10 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах журамд заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын алба, Үндэсний аудитын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Төрийн албаны зөвлөл, Жендэрийн Үндэсний хороо, Авлигатай тэмцэх газар, Удирдлагын академийн төлөөллийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бөгөөд комисс Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль, журамд нийцүүлэн ажиллалаа.

Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах зарыг 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс Улсын Их Хурлын болон Төрийн албаны зөвлөлийн цахим хаягаар олон нийтэд долоо хоногийн хугацаанд нээлттэй байршуулж, Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйлд заасны дагуу сонгон шалгаруулалт оролцогчдын материалыг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 17 цаг 30 минут хүртэл хүн тус бүрээр тэмдэглэн хөтлөн битүүмжлэн хүлээн авсан болно.

Комисс анхны хуралдаанаараа битүүмжлэн хүлээн авсан 6 иргэний материалыг нээж, бүртгэл хяналтын хуудсыг гишүүн бүр нягтлан хөтөлж тэмдэглэн холбогдох байгууллагуудаас мэдээлэл, лавлагаа авах, бусад шаардлагатай материалыг нягтлан шалгах, ажлын төлөвлөгөө, ажил үүргийн хуваарь болон сонгон шалгаруулалтын ярилцлагын дэгийг батлах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Комисс хоёр дахь хуралдаанаараа материал ирүүлсэн Д.Баатарсайхан, Д.Санжрагчаа, Х.Ган-Очир, Д.Одхүү, Ц.Амартөгс, Б.Төгсцэнгэл нарын 6 оролцогчийг бүртгэх эсэх асуудлыг журамд заасны дагуу хүн тус бүрээр хэлэлцэн, оролцогчдын ирүүлсэн материал, мөн түүнчлэн журамд заасан шаардлагыг хангаж буй эсэхийг Төрийн албаны зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газраас авсан лавлагаа зэрэгтэй нэг бүрчлэн танилцаж, журамд заасны дагуу хянан шийдвэрлэлээ.

Тухайн албан тушаалд тавигдах шаардлага болох төрийн албан хаагч байх, дээд боловсролтой, 45 нас хүрсэн, төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй, түүнээс эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан, мэргэшсэн байх, зөвлөлийн гишүүдтэй хамаарал бүхий эсэх талаар хүн нэг бүрээр хэлэлцэн, сахилгын шийтгэл хүлээж байгаагүй, ял шийтгүүлж байгаагүй болон сүүлийн нэг жилийн хугацаанд улс төрийн намын аль нэг байгууллагад сонгуульт болон бусад албан тушаалд эрхэлж байгаагүй байх шаардлагыг Д.Баатарсайхан, Д.Санжрагчаа, Х.Ган-Очир, Ц.Амартөгс, Б.Төгсцэнгэл нарын 5 оролцогч хангасан тул бүртгэхээр шийдвэрлэсэн болно.

Оролцогч Д.Одхүү нь журмын 1.5-д заасан төрийн албан хаагч байх шаардлагыг хангаагүй.

2024 оны 12 дугаар сарын 19-ний Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 285 дугаар тогтоолоор ажлаас чөлөөлөгдсөн байх тул бүртгэх боломжгүйг санал, дүгнэлт тусган, тус иргэнд мэдэгдэн баталгаажуулсан болно.

Бүртгэгдсэн 5 оролцогчийн мэдлэг, боловсрол, мэргэшил, туршлага, мэргэжил, ур чадварт комисс үнэлгээ өгч 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр 100 хувийн ирцтэйгээр Төрийн албаны зөвлөлийн гишүүнд төрийн албаны төлөөлөл болон нэр дэвшиж, сонгон шалгаруулалтын шаардлага хангасан 5 оролцогчидтой журамд заасны дагуу ярилцлага хийж, үнэлгээг хараат бусаар өгч, оролцогч тус бүрд үнэлгээг танилцуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2018 оны 10 дугаар тогтоолоор баталсан төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах журмын 7.1-д комисс үнэлгээг эцэслэн нягталж, онооны дарааллаар хамгийн эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн нэр, сонгон шалгаруулалт явуулсан тухай тайлан, холбогдох баримт бичгийг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд сонгон шалгаруулалт дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан хүргүүлнэ гэж заасны дагуу нийт үнэлгээгээр хамгийн эхэнд эрэмбэлэгдсэн Цэнддаваагийн Амартөгс 87.1 оноо, Бадамдоржийн Төгсцэнгэл 86.2 оноо нарыг нэр дэвшүүлэн шалгаруулалтын тайлан болон холбогдох материалыг Байнгын хороонд хүргүүлсэн.

Нийт үнэлгээгээр хамгийн эхэнд эрэмбэлэгдсэн Цэнддаваагийн Амартөгс нь эдийн засагч мэргэжилтэй, төрийн удирдлага болон бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй.

Төрийн албанд 25 жил, дэс түшмэлийн албан тушаал 8.8, эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 12, тэргүүн түшмэлийн албан тушаалд 4.7 жил ажилласан туршлагатай.

Үүнээс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хэлтсийн дарга, газрын орлогч дарга, газрын дарга, Төрийн албаны зөвлөл хэлтсийн дарга, ажлын албаны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна.

Тэрээр 1976 онд Улаанбаатар хотод төрсөн, 49 настай.

Дараагийн хамгийн өндөр оноогоор эрэмбэлэгдсэн оролцогч Б.Төгсцэнгэл эрх зүйч мэргэжилтэй, хуулийн магистрын зэрэгтэй.

Төрийн албанд 15 жил, ахлах түшмэлийн албан тушаалд 8, эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 5.5, тэргүүн түшмэлийн албан тушаалд 1 жил гаруй ажилласан туршлагатай.

Үүнээс Улсын Их Хурлын Тамгын газрын Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтсийн шинжээч, референт, Хууль зүйн үйлчилгээний хэлтэс, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албанд референт, зөвлөх, дотоод хяналтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч албан тушаалыг хашиж байна.

Тэрээр 1978 онд Төв аймгийн Мөнгөнморьт суманд төрсөн. 47 настай.

Комиссын тайланг танилцуулж дууслаа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн ахлагчид талархлаа.

Ажлын тайлангаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Б.Баярбаатар даргаар тасаллаа. Э.Болормаа гишүүнээр тасаллаа. Б.Баярбаатар гишүүний микрофон.

Б.Баярбаатар: Ажлын хэсгийн мэдээлэлтэй сонслоо.

5 хүн орж ирсэн байна. Тэгээд эндээс 2 нь шаардлага хангаад өнөөдөр Байнгын хороонд танилцуулагдаж байна гэж ойлгож байгаа.

Сонсгол чинь одоо энэ Байнгын хороогоор явах уу? Дарга. Тусдаа явах юм уу? Сонсгол манай дээр явах уу? Тийм ээ.

Би энэ 2 хүнийг дэмжиж байгаа юм. Нэгдүгээрт, Ц.Амартөгс гээд Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Ёс зүйн хорооны дарга хийж байгаа.

Ёс зүй, дэгийн байнгын хорооны даргын хувьд ч тэр, Төрийн байгуулалтын байнгын хорооны даргын хувьд ч тэр өнөөдөр бид энэ төрийн албыг чадавхжуулах, төрийн албыг ёс зүйтэй болгох, цаашлаад төрийн албаараа дамжуулж ёс суртахууны төлөвшлийг нийгэмд түгээх гэсэн бодлогын шийдвэрүүдийг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа.

Тэгээд орж ирж байгаа 2 хүнийг хоёуланг нь дэмжинэ. Б.Төгсцэнгэлийн хувьд ч гэсэн бас дэмжлэг авах боломжтой гэж харж байгаа.

Гол нь шаардлага хангаагүй улсуудыг та сая нэгийг нь л дурдах шиг боллоо. Би буруу сонсоогүй бол. Бусад нь яг ямар ямар хүн орж ирээд ямар байдлаар шаардлага хангаагүй юм бол. Одоо өнөөдөр энэ Төрийн албаны зөвлөлөөс яг хэдэн гишүүд хугацаа нь дуусаад, ямар ямар хүний санал болгосон гишүүд чөлөөлөгдөхөөр байгаа вэ гэдэг мэдээллийг Та надад нэг өгөөч.

Ц.Сандаг-Очир: Гишүүний асуултад ажлын хэсгийн 5 номерын микрофоныг өгье.

Б.Хатантуул: Б.Баярбаатар гишүүний асуултад хариулъя.

Нийт 6 иргэн бүртгүүлэхээр материалаа ирүүлснээс Төрийн албаны тухай хууль болон 2018 оны Төрийн байгуулалтын байнгын хорооны 10 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу 5 оролцогчийг бүртгэсэн.

Д.Баатарсайхан, Д.Санжрагчаа, Х.Ган-Очир, Ц.Амартөгс, Б.Төгсцэнгэл нар бүртгэлийн шаардлагыг хангаж, тавуулаа ярилцлагад оролцсон.

Ярилцлагад оролцсоноороо хамгийн өндөр оноогоор эрэмбэлэгдсэн Ц.Амартөгс, Б.Төгсцэнгэл нарыг нэр дэвшүүлэн Байнгын хороогоор танилцуулж байгаа юм.

Тухайн оролцогч нарыг хэрхэн яаж дүгнэдэг вэ гэхээр

- ▶ Мэдлэг, боловсролын түвшний оноо,
- ▶ Төрийн албаны мэргэшил, туршлагын үнэлгээний оноо,
- ▶ Мэргэжил, ур чадварын оноо,
- ▶ Ярилцлагын оноо

гэсэн ийм 4 ангиллаар үнэлж нийт оноог гаргадаг.

Тухайн оноог гаргах аргачлал нь өөрөө 2018 оны Төрийн байгуулалтын байнгын хорооны 10 дугаар тогтоолоор баталсан журамд заасан байдаг.

Хоёр дахь асуултад хариулъя.

Төрийн албаны зөвлөл нь өөрөө нийт 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажилладаг. Өнөөдрийн байдлаар Төрийн албаны зөвлөлийн даргаар Л.Цэдэвсүрэн.

Гишүүдэд Б.Пүрэвдагва, Б.Идэрчулуун, Ц.Баатарсайхан, Ц.Амартөгс гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

5 гишүүнээс Б.Идэрчулуун гишүүн, Ц.Баатарсайхан гишүүн, Ц.Амартөгс нарын гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 2025 оны 02 сарын 04-ний өдөр дууссан байгаа тул энэ сонгон шалгаруулалтыг зарлаж, нэр дэвшүүлэх үйл ажиллагааг явуулж байна.

Төрийн албаны тухай хуульд зааснаар дараагийн гишүүн томилогдсоноор өмнөх гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж байгаа.

6 жилийн хугацаатай.

Энэ комиссын бүрэлдэхүүн бол төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах бүрэлдэхүүн байгаа. Хуулиар Ерөнхийлөгчийн Тамгын газраас 1, Улсын Их Хурлын Тамгын газраас 1, Засгийн газрын Хэрэг эрхлэхээс 1, төрийн албан хаагчийн төлөөллөөс 2 гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр 5 гишүүн ажилладаг.

Б.Идэрчулуун гишүүний хувьд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас квоттойгоор ажиллаж байгаа гишүүн.

Ц.Сандаг-Очир: Э.Болормаа гишүүн асуултаа асууя.

Э.Болормаа: Бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгээд нэр дэвшигч нар сонсгол явагдаагүй. Бид илүү процессын талаар асуулт асууж байна гэж ойлгож байна.

Тэгэхээр бид сая хуулийнх нь хаанаас квоттойгоор Төрийн албаны зөвлөлд ордгийг тайлбарлалаа л даа. Ер нь цаашдаа сонгон шалгаруулалтыг илүү, магадгүй хүний нөөцийн менежмент ч юм уу, би олон улсын байгууллагуудын туршлагаас яадаг вэ гэхээр Дэлхийн банк ч юм уу, НҮБ ч юм уу дотоод хүний нөөцөөс гадна гаднын хүний нөөцийн компаниудтай хамтарч зарим сонгон шалгаруулалтыг хийдэг.

Төрийн албаны зөвлөлтэй ажиллаж байсан туршлагаас маань юу вэ гэхээр танил талаараа асуудал явагдах юм байх гээд байдаг. Тэгээд бид мерит зарчмаар төрд аягүй олон жил ажилласан хүмүүсийг оруулж ирж байгаа боловч түүний мэдээж сайн тал, сул тал нь аль аль нь гарч ирдэг юм. Сул тал нь яг л энэ системийнхээ бүтээгдэхүүн.

Тэгээд энэ системийн бүтээгдэхүүн байна гэдэг нь одоо би сул гэж хэлээгүй ч гэсэн яг өнөө цагт бид төрийн албаны шинэчлэл гэдэг юмыг аягүй их шаардсан үе болж байгаа.

Тэгэхээр бид нийт 6 гишүүний 2-ыг гуравны нэг бүрэлдэхүүнийг гаргаж ирэх гэж байна. Би энэ 2 нэр дэвшигчийн Та бүхний өгсөн танилцуулга доторх үндэслэлийг нь л харж байна л даа. Би эндээс нэг тийм шинэчлэл ерөөсөө харагдахгүй байхгүй юу. Яг төрийн албанд ажиллаж байсан хүмүүс маань ингээд л явдаг.

Тэгэхээр энэ хүмүүс гэхээсээ илүү бид сонгон шалгаруулах процесс нь өөрөө алдаатай байна уу. Бид хүсээд байгаа тэр төрийн албаны шинэчлэлээ хийх хүмүүсийг оруулж ирэх боломжгүй юм болов уу гэдэг ийм байдал уншигдаж байна. Жишээлбэл, манай Хэрэг эрхлэхээс зөндөө л тэр Сингапурын жишээг

судалж байна. Дэлхийд ч гэсэн сайн гээд л. Тэр нь хувийн хэвшилтэй уялдуулдаг ч юм уу. Тийм ээ. Яг шилдэг хүний нөөцийн менежментийн хүн жишээлбэл одоо манай Төрийн албаны зөвлөлд орж ирэх ямар ч боломжгүй байна л даа.

Тэгэхээр энэ процессын талаар нээлттэй Та бүхнээс асууя. Яг өнөөдрийн энэ процессоос үүдэлтэйгээр бид төрийн албаны шинэчлэлийг яаж хийх юм бэ? Яг л энэ системээс гарсан хүмүүсээ тэнд тавиад л, тэгээд л тэд нараасаа өөрсдийнхөө бий болгосон системийг өөрчилье гэдэг шаардах нь өөрөө доголдолтой санагдаад. Энэ бүтэн сонгон шалгаруулалтын явц нь жоохон доголдолтой юм болов уу гэсэн ийм асуулт, саналтай байна.

Ц.Сандаг-Очир: Гишүүний асуултад ажлын хэсгийн 5 номерын микрофоныг.

Б.Хатантуул: Э.Болормаа гишүүний асуултад хариулъя.

Комисс ч бас сая сонгон шалгаруулалт явуулахдаа. Э.Болормаа гишүүнтэй санал нэг байгаа. Төрийн байгуулалтын байнгын хорооны хувьд эрхлэх асуудал нь төрийн алба бүхэлдээ явж байгаа. Төрийн албаны шинэчлэл хийх, төрийн албаны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон саяын хэлээд байгаа 2018 онд батлагдсан Төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах журамд өөрчлөлт оруулах бүрэн боломжтой гэж харж байна.

Сонгон шалгаруулах журмын 6-д оролцогчийн мэдлэг боловсролын түвшнийг үнэлэхдээ боловсролын зэрэг, бакалавр, магистр, доктор нь гэж харж байна.

Мөн Төрийн албаны тухай хуульд заасан 45 нас, дээд боловсролтой байхыг харж байна.

Мөн энэ журамд зааснаар тухайн төрийн албан хаагчийн ажилласан мэргэжил, туршлагын үнэлгээг үнэлэхдээ

- туслах түшмэл,
- дэс түшмэл,
- ахлах түшмэл,
- эрхэлсэн түшмэл,
- тэргүүн түшмэлийн

ангилалд ажилласан жилийг нь коэффициентоор үржүүлж гаргаж байна.

Мөн түүнчлэн хуулийн төсөл, салбарын болон орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын зорилго, зорилтыг

тодорхойлох, хамт онолоо манлайлах, тулгарсан асуудалд дүн шинжилгээ хийж, үндэслэл бүхий шийдвэр гаргаж байгаа байдлаар нь үнэлгээ өгч байгаа.

Мөн түүнчлэн ярилцлагыг хийхдээ төрийн албаны шинэчлэл, хүний нөөцийн бодлогын талаарх оролцогчийн байр суурийг тодорхойлж, асуулт асууж, дүгнэж гаргаж байгаа.

Тэгээд Э.Болормаа гишүүний асуултад дахин хэлэхэд манай Байнгын хорооны хувьд энэ шинэчлэлийг манлайлаад хийх бүрэн боломжтой байгаа.

Ц.Сандаг-Очир: Э.Болормаа гишүүн тодруулга 1 минут баярлалаа.

Э.Болормаа: Тэгэхээр сонгон шалгаруулалтын комисс энэ дээр санал нэгтэй байна гэж байна шүү дээ.

Тэгэхээр миний хэлэх гэж байгаа санал болоод асуулт. Одоо бид энэ 2 хүнийг шалгаруулахыг түр зогсооё.

Энэ 2 хүний хувь нэр дэвшигчтэй огт холбоотой асуудал биш. Сонгол явагдаагүй. Зүгээр үүнийг хойшлуулаад энэ процесс руугаа эхлээд орвол яасан юм бэ. Яг саяын энэ сонгон шалгаруулалтын яг юуг нь бид бид үнэлээд байгаа юм, ажилласан жилийг нь бид коэффициентлоод, нөгөө өөрчлөх гээд байгаа мерит зарчмаараа бид хүн сонгон шалгаруулаад байхаар эхлээд энэ рүүгээ орвол яасан юм бэ гэсэн ийм саналтай байна.

Таны хэлснээр хэрвээ манай Байнгын хороонд бүрэн эрх мэдэл нь байгаа бол 2 хүнийг хэн ч бай, одоо энэ 2 маань мундаг байж болно л доо. Тэгэхдээ 6 жилээр гэдэг бол өнөөдөр би хувьдаа үнэхээр бид нарын тулгамдаж байгаа топ 5 асуудлын нэг болох төрийн албаны шинэчлэл гэдгээ хийх бид гуравны нэг боломжоо алдаж байна л гэж.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Санал. Тийм ээ. Хойшлуулж болох уу гэж байна. Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Б.Хатантуул: 04 сарын 16-ны Төрийн байгуулалтын байнгын хорооны тогтоолоор 05 сарын 20-ны дотор комисс сонгон шалгаруулалтаа хийж, ажлын тайлангаа хүргүүлж, Байнгын хороонд тайлагнах үүрэг өгсөн.

Түүний дагуу комисс үйл ажиллагаагаа хийгээд өнөөдөр тайлангаа танилцуулж байна. Цаашдаа Э.Болормаа гишүүний саналаар энэ журам болон Төрийн албаны хуульд өөрчлөлт хийх боломжтой.

Ц.Сандаг-Очир: Өнөөдрийн батлагдсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төрийн албаны хуулиараа процедур явж байгаа.

Ярьж байгаа асуудлыг цаашдаа илүү шинэчлэх сайжруулах шаардлагатай гэж үзвэл тэр сонгон шалгаруулах Төрийн албаныхаа хуульд нэмэлт, өөрчлөлт оруулалттай явах бололцоо боломж бий гэж байна.

2025 оны Байнгын хорооны 04 дүгээр тогтоолоор байгуулагдсан сонгон шалгаруулах комиссын ажлын тайлангаас гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Санал хураалтгүй юм байна. Тийм ээ. Тогтоол шийдвэр гарахгүй юм байна.

Үүний хоёр дахь асуудал нь болохоор Байнгын хорооны тогтоолын төсөл. Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай.

Хоёр дахь хэлэлцэх асуудалдаа орёе.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

Байнгын хорооны тогтоолын төслийг Та бүхэндээ уншиж танилцуулъя. Гишүүдэд Төрийн албаны зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Гишүүдэд бас тараасан байгаа байх. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг, 130 дугаар зүйлийн 130.1.1 дэх заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.3 дахь хэсгийг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Цэнддаваагийн Амартөгс, Бадамдоржийн Төгсцэнгэл нартай хийх нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2.Нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийг томилсугай.

3.Нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл хүлээн авахаар тогтоосугай.

4.Нэр дэвшигчийн сонсголын талаар нийтэд мэдээлэх, сонсголын бэлтгэл хангах ажлыг холбогдох хууль, журамд заасны дагуу зохион байгуулахыг Төрийн байгуулалтын байнгын хороо /Ж.Бат-Эрдэнэ/-д даалгасугай.

Ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төслөөс асуух асуулттай гишүүд байна уу? Э.Болормаа гишүүнээр тасаллаа. Э.Болормаа гишүүний микрофоныг өгье.

Э.Болормаа: Ингээд дахиад л би энэ алдаатай, доголдолтой процессоор энэ 2 хүнээс үл хамаараад бид шууд үүнийг явуулах гээд байна л гэж харж байна л даа.

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан “Төрийн албаны шинэчлэлийн ажлын хэсэг” гэж байгаа. Бид шинэчлэлийг нэлээн нэн тэргүүнд тавьсан юм чинь тэр ажлын хэсэг ямар байр суурьтай байгаа юм?

Энэ сонсгол хийгээд томилох хүмүүс Улсын Их Хурлын гишүүнээс удаан бүрэн эрхийн хугацаатай. Бид Улсын Их Хурлын гишүүн бөөнөөрөө л ер нь энэ дунд шатны болохгүй байгаа зүйлс, төрийн албаны шинэчлэлийг ярьдаг боловч яг үүнийг гүйцэтгэж хийх бүрэн эрх мэдэлтэй субъект нь Төрийн албаны зөвлөлийн гишүүд болоод байдаг.

Тэгэхээр бид энэ дээрээ нэлээн нухацтай хандах ёстой юм болов уу. Зүгээр байдгаар нь юмыг явуулбал бид нарын хүссэн шинэчлэл болохгүй.

Тэгэхээр өнөөдөр үүнийгээ явуулах хэдий амархан ч гэсэн би үүнийг дэмжихгүй байна. Үүнийг хойшлуулаад бид төрийн албаны шинэчлэлийн тэр ажлын хэсгийг сонсьё. Яг ямар шинэчлэл хийх гээд байгаа юм. Түүний өөрчлөлтийн гарц гаргалгааг хайя. Бид Байнгын хороон дээрээ тогтоол хийж болох юм уу, журамд өөрчлөлт болох юм уу, эсвэл хуулийнхаа өөрчлөлтийн тэрийг нь хэсэгчлээд тастаад ч болтугай өөрчлөлт оруулаад эндээ дахиад нэг нухацтай хандвал яасан юм бэ? Шинэчлэл хийе гээд яг л нөгөө бахь байдгаараа юм хийх юм бол шинэчлэл хаанаас ч гарч ирэхгүй шүү дээ гэсэн ийм саналтай байна.

Тэгэхээр би Байнгын хорооныхоо гишүүддээ тэгээд энэ 2 нэр дэвшигчдэдээ бас хүлцэл өчөөд, энэ 2 нэр дэвшигчийг би хувьдаа танихгүй. Энэ 2-ын чадамжаас үл хамаараад энэ процесс өөрөө доголдолтой байна гэж үзэж байна.

Тэгэхээр төрийн албаны шинэчлэлээ бид хийе гэж байгаа бол энэ Төрийн албаны зөвлөлийн гишүүдийн томилгооноос эхлэх ёстой юм шүү.

Тэгэхээр Байнгын хорооныхон бүгдээрээ үүнийг хамтдаа хойшлуулъя гэсэн саналтай байна.

Ц.Сандаг-Очир: Тэгээд л саналаа хураагаад л явна. Тэгээд дэмжигдвэл дэмжигдээд явна. Дэмжигдэхгүй бол тэгээд явах нь.

Санал хураалт. Гишүүд ирц хүрч байна уу? 8. Э.Болормаа гишүүн байр сууриа илэрхийлж байгаа. Тэгэхээр санал хураалт чинь явах юм уу? Хүрэх юм уу? Дэмжигдэх юм уу?

Гишүүд анхааралтай. Санал хураалт. Эхний санал хураалт.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийг сонсгол даргалагчаар сонгохыг дэмжье гэсэн томъёоллоор санал хурааа. Санал хураалт. /алх цохив/

13 хүнээс 6 хүн дэмжиж, 46.2 хувиар санал дэмжигдсэнгүй.

Б.Баярбаатар гишүүн горимын санал гаргаж байна.

Б.Баярбаатар: Гишүүд ээ, яах вэ одоо сонсголыг хойшлуулах саналыг гаргаж байгааг хүндэтгэж байна.

Тэгэхдээ өнөөдөр би одоо сая 2 сарын хугацаанд төрийн албан хаагчийн бүсчилсэн зөвлөгөөнд бүх бүс дээр очиж оролцоод, өөрөө илтгэл тавиад, яг дунд нь ороод ажиллаад ирсэн.

Өнөөдөр Төрийн албаны зөвлөлийн бүрэлдэхүүн тодорхой түвшинд цус сэлбэлттэй орж ирж байгаа юм. Жишээлбэл, одоо энэ Б.Төгсцэнгэл гээд залуу бол олон жил төрийн захиргаагаар явсан залуу хүн байгаа. Өмнө нь Төрийн албаны зөвлөлийн гишүүн байгаагүй.

Энэ Ц.Амартөгсийн хувьд бол яг бүр нэг бүтэн бүрэн эрхийн хугацаанд ажиллаагүй. Нэгд.

Хоёрт гэх юм бол сая сүүлд сонгогдсон.

Гуравт гэх юм бол Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль гээд анхдагч хууль батлагдаад хэрэгжээд удаагүй байгаа. Энэ Ёс зүйн хороог толгойлоод ажиллаж байгаа юм. Энэ ажлыг нь үргэлжлүүлээд хийлгэхгүй бол энэ өөрөө өнгөрсөн 30 жилийн хугацаанд бид энэ хүнд суртал, ёс суртахуунд хариуцлага тооцдог байгууллагагүй ирсэн юм.

Анх удаа бид энэ Ёс зүйн хороо гэдэг байгууллагыг Төрийн албаны зөвлөлийн дэргэд байгуулаад өнөөдөр бид нэг төлөвшлийг нь олуулах гээд нэлээн хичээж ажиллаж байгаа юм.

Магадгүй зарим орон нутгуудын төрийн албан хаагчийн томилгоо хууль бус явсан иймэрхүү зүйлүүд дээр өнөөдөр Төрийн албаны зөвлөл хангалтгүй ажиллаж байгааг би хүлээн зөвшөөрнө. Би өөрөө сая баруун бүсэд ажиллахдаа ч гэсэн энэ дээр бас нэлээдгүй хатуу байр суурь илэрхийлээд ирсэн. Улс төржсөн нөхцөл байдлыг энэ төрийн албанаас яаж холдуулах вэ, улс төржсөн томилгоог яаж энэ төрийн албанаас холдуулах вэ гэдэг агуулга дээр хандаж байгаа.

Тэгэхээр бид энэ төрийн албаны шинэчлэлийг эрх зүйн зохицуулалтаар хийх ёстой гэж харж байгаа. Энэ төрийн албаныхаа хуулиар, энэ бусад дагалдах хуулиудаар, өнөөдөр мөрдөгдөж байгаа журмуудад үнэлгээ хийж байж энэ Төрийн албаны хуулийн асуудал, төрийн албаны шинэчлэл явагдах ёстой гэсэн ийм байр суурь дээр харж байгаа. Тодорхой түвшний мэдээж өвдөлт орж ирэх байх.

Тэгэхдээ өнөөдөр бид энэ сонсголоо зохион байгуулдгаараа зохион байгуулаад явах нь зүйтэй болов уу гэсэн ийм саналыг гаргаж байна. Ж.Бат-Эрдэнэ дарга дэмжигдсэнгүй унахаар хурлын дарга та дахиад өөр хүнээр дэвшүүлээд, энэ С.Зулпхар гишүүнийг ч юм уу сонсгол даргалагчаар оруулж ирээд санал хураагаад явсан нь зөв байх гэсэн саналтай байна.

Ц.Сандаг-Очир: О.Алтангэрэл гишүүн.

О.Алтангэрэл: Сая жишээлбэл дэмжиж санал өгсөн.

Тэгэхдээ нэг юман дээр гайхаад байгаа юм. Төрийн байгуулалтын байнгын хороо сүүлийн үед ирц дээр ер нь маш их асуудалтай. Олон дарга нартай.

Тэгээд манай Байнгын хорооны ажлын албаныхан ер нь ирцээ бүрдүүлэх гээд л зөндөө юм болдог. Тэгээд бүрдүүлсэн хэд нь орж ирээд суугаад саналаа өгөх гэхээр одоо энэ санал чинь унах гээд байна, унах гээд байна. Дахиж хураая гээд.

Тэр бусад хүмүүс нь хуралдаа суухгүй байгаад энд сууж байгаа хүмүүс нь буруутай биш. Дээрээс нь Улсын Их Хурлын гишүүн бол хэнээс ч ямар ч нөлөөллөөс үл шалтгаалан саналаа өөрсдийнхөөрөө өгөх эрхтэй. Саяын тогтоол батлагдсангүй.

Үнэхээр энэ батлагдахгүй байгаа бол одоо байгаа ирцээрээ хуралдвал хуралдаж чадаад, хуралдаж чадахгүй бол хуралдаж чадахгүйгээрээ байгаа ирцээрээ хэдүүлээ асуудлаа даруй түргэн шийдвэрлээд өнөөдрийн хэлэлцэх асуудлаа шийдвэрлээд явъя гэсэн ийм санал гаргаж байна.

Ц.Сандаг-Очир: О.Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Сая би Б.Хатантуул зөвлөхтэй энэ дэгийг нь харлаа л даа.

Ер нь логикийн хувьд сая Ц.Сандаг-Очир даргын хэлж байгаачлан дэгээ бид харахгүй бол энэ чинь сонсгол эхлэлт нь бүхэлд нь явуулах юм уу, үгүй юу гэдгийгээ шийдэж байж даргалагчаа тэгвэл хэн байх вэ гэдгийг шийддэг байхад сонсгол явна гэдэг претенз дээр даргалагчаа эхлээд сонгоё гэдэг санал хураалт явчхаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр дэг дээрээ, дараалал дээрээ яаралтай өөрчлөлт оруулаад. Эхлээд энэ сонсголоо ер нь энэ 06 сарын 03 гэнэ үү, хэнд гэнэ үү явуулах юм уу, үгүй юу гэдэг нь тогтоолынхоо агуулгаар эхлээд санал хураамаар байна.

Тэгсний дараа тэр даргалагчийн асуудал яригдах учраас энэ санал хураасан дараалал өөрөө буруу байна.

Тэгэхээр үүнийг дарааллын зөв болгож одоо тэр санал хураалтаа О.Алтангэрэл сайдын хэлж байгаагаар одоо үүгээрээ санал хураахаас өөр яахгүй.

Тэгээд ажил үүрэгтээ хариуцлагагүй. Тэгээд орж ирээд ирцээ бүртгүүлчхээд гараад явчихдаг, хэзээ ч оролцдоггүй хүмүүсийг бид санал хураалт болохоор кнопчин гээд дуудах юм уу. Тийм ээ. Ирэх ч үгүй байна шүү дээ. Ер нь тэгээд ажлаа хийж байгаа хүмүүс нь цаг тухайдаа хийгээд, асуудлаа хэлэлцээд, яриад, шийдвэрээ гаргаад явах нь зүйтэй л гэсэн байр суурьтай байна.

Ц.Сандаг-Очир: О.Номинчимэг гишүүн дахин горимын санал гаргаж байна.

О.Номинчимэг: Тэгэхээр саяын санал хураалтын дараалал буруу явсан учраас горимын санал гаргаад, саяын санал хураалтыг хүчингүй болгоод, эхлээд сонсгол үнэхээр явуулах юм уу, үгүй юм уу. Энэ тогтоолд туссан агуулгаар нь тогтоолынхоо санал хураалтыг явуулъя гэсэн горимын санал гаргаж байна.

Ц.Сандаг-Очир: Ойлголоо. Харин тийм байна. Энэ дараалал бас буруу л хийгдсэн юм шиг байна гэж хараад байна.

Эхлээд энэ сонсголыг явуулах эсэх асуудлаар Байнгын хорооны тогтоолоо баталчхаад, дараа нь дэмжигдвэл энэ сонсголыг хэн удирдах вэ гэдгээ дэмжээд тогтоолоо батлуулаад явах нь дарааллын хувьд, логикийн хувьд зөв юм шиг харагдаж байна.

Гэтэл сая бид чинь эсрэгээр нь эхлээд тогтоолоо батлаагүй байж сонсгол даргалагчийг шууд сонгох асуудлаар санал хураагаад явахаар чинь буруу болчихоод байна.

Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож санал хураалтыг дахин явуулъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. О.Номинчимэг гишүүний горимын саналаар.

О.Номинчимэг гишүүний гаргасан горимын санал 53.8 хувиар дэмжигдлээ.

Одоо санал хураалт явуулна. Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулах гэж байна. Гишүүд ээ. Санал хураалт. Анхааралтай байгаарай. /алх цохив/

13 гишүүнээс 5 гишүүн нь дэмжиж, 38.5 хувиар санал хураалт дэмжигдсэнгүй.

Энэ асуудал өнөөдөр дэмжигдээгүй учраас дахин хойшлуулж байна. Хоёр дахь асуудал дэмжигдээгүй хойшлогдсон.

Гурав дахь асуудалдаа орьё.

**Гурав.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар
хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг
чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал**

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулна. Санал хураалт явуулъя.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 05 сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их

Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 61.5 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр.Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 05 сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

13 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 69.2 хувиар санал дэмжигдлээ.

Гурав.Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

8 гишүүн дэмжиж, 61.5 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Дөрөв.“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай”

Улсын Их Хурлын тогтоолын төсөл

/Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн,

хоёр дахь хэлэлцүүлэг,

Санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

Дөрөв дэх асуудал.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Засгийн газар 2025 оны 04 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хоёр дахь хэлэлцүүлгийг явуулна. Санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ.

Ажлын хэсгийг оруулъя.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл Засгийн газар 2025 оны 04 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хоёр дахь хэлэлцүүлэг. Ажлын хэсгийг танилцуулъя.

Б.Даваадалай Монгол Улсын Ерөнхийлөгчийн эдийн засгийн бодлогын зөвлөх гэж байна. Б.Баасандорж Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга. Энэ ажлын хэсгийнхэн чинь хаачихсан юм.

Д.Баяндүүрэн Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн байна. Д.Ариунболд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга, В.Жавзан Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга, Д.Бат-Эрдэнэ Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга байна. И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга байна. Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга. Ж.Ганбат дарга сая гадаа явж байсан. Хаачив. Дуудаарай. Ц.Эрдэнэбат Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч байна, Д.Баттогтох Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга алга байна. Б.Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга алга байна. Ж.Өнөржаргал Эдийн засаг, хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын даргын албаны үүргийг түр орлон гүйцэтгэгч алга байна. Л.Балчинлуvsан Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн хэлтсийн Төслийн бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч. Энэ чинь одоо дандаа түр орлон гүйцэтгэгч нар юм уу, хаашаа юм. Байна. М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга. Б.Тэлмүүн Сангийн яамны татварын бодлогын газрын дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Б.Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, О.Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга, Б.Ганзориг Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, З.Райынбек Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын ахлах мэргэжилтэн, Г.Отгонцэцэг Эдийн засаг, хөгжлийн яамны Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Т.Хонгор Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн шинжээч.

Ажил ажлын хэсгийг танилцуулж дууслаа. Танилцуулга байхгүй юм байна. Хоёр дахь хэлэлцүүлэг учраас.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд. Асуулт, санал цуг юм байна шүү. Саналтай гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт, санал цуг шүү.

Г.Уянгахишиг гишүүнээр, Ж.Баярмаа гишүүнээр нэр авч дууслаа. С.Зулпхар гишүүний микрофоныг өгье.

Гишүүд санал хураалттай шүү. Ирцээрээ Б.Баярбаатар гишүүн. Б.Баярбаатар гишүүний микрофоныг.

Б.Баярбаатар: Асуулт байна. Төрийн албатай л холбоотой асуулт.

Энэ тэргүүлэх чиглэл дотор төрийн албаны реформ гэнэ ээ. Тэгээд төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгаж, төрийн албан хаагчийн тоог багш, эмч нараас бусад төрийн албан хаагч нарын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ гэж байгаа юм.

Тэгээд энэ зүгээр тооцоолоод үзэхээр төрийн захиргааны 50 орчим мянган төрийн албан хаагч, үүний 9, 10 хувь гэхээр 4500-аас 5000 төрийн албан хаагчийг цомхотгох гэж байгаа юм байна. 2026 онд. Тэгээд энэ нэгдүгээрт яг реформ мөн үү?

Хоёрт, үүнийг яг хэрхэн, ямар аргачлалаар хийх гэж байгаа юм? Энэ төрийн албаны сэлгэн ажиллуулах, төрийн албыг шинээр бүрдүүлэх гээд олон шинэчлэлүүдийг хийх гээд төрийн албан хаагчдаасаа саналыг нь аваад явж байгаа л даа. Эсвэл тэтгэврийн нас нь болсон төрийн албан хаагчдаа орон тоог нь нөхөх бодлогогүйгээр явах гэж байгаа юм уу? Эсвэл ерөөсөө шууд ажил хийдлийн давхардал гээд шууд байгууллагуудад танай байгууллага тэдийг, танай байгууллага тэдийг гээд квот өгөөд 5 мянган хүнийг амьдралгүй болгох гэж байна уу?

Тэгээд энэ бүхний цаана хувь хүний амьдрал, айлын амьдрал, олон асуудал байгаа гэдгийг ер нь энэ хөтөлбөр боловсруулж байгаа улсууд ойлгож байгаа болов уу?

Тэгээд дараа нь тэр ажлын байрнаасаа салсан улсуудын үүрэг, хариуцлагыг нь хэн үүрэх вэ? Анхнаасаа бид үүнийгээ бодож ажил төрөлдөө авдаггүй байсан юм уу? Түүний оронд өнөөдөр бид энэ төрийн албаны томилгооноос улс төржилтийг ангид байлгана гэдэг заалт оруулж ирсэн бол арай амьд байх байсан юм.

Өнөөдөр энэ улс төрийн томилгоог төрийн алба руу хэт шингэснээр өнөөдөр энэ төрийн албаны чинь нэр хүнд унаад, чадамж нь сулраад байгаа шүү дээ. Бүтээмж нь буураад байгаа шүү дээ. Тэгээд “нэг үхрийн эвэр доргихоор мянган үхрийн эвэр доргино” гэж үг байдаг. Тэгээд нэг төрийн албан хаагчийн чадамжгүй байдлаас болоод нийт төрийн албан хаагчдын нэр хүнд унаад байдаг нөхцөл байдал цаашид байж болохгүй гэж харж байгаа.

Тэгэхээр үүний энэ томъёололыг би ерөөсөө ойлгохгүй байна. Яаж өөрчлөх ёстой юм? Энэ цомхотгосноороо шинэчлэл болдог юм уу, реформ болдог юм уу? Хэрвээ тэгдэг бол одоо тэгээд тэр хангалттай тоогоороо цомхотгох гэж байгаа юм бол одоо тэгээд бараг талыг нь цомхотгосон нь дээр байлгүй дээ. Тийм мундаг реформ хийх гээд байгаа юм бол.

Тэгээд хаана, яг ямар байгууллага дээр энэ цомхотголыг хийх гэж байгаа юм? Ерөнхий агуулга ярьж болохгүй шүү дээ. Энэ нэг жилийн хугацаанд хийж хэрэгжүүлэх ажил шүү. Хаана ийм давхцал байгаад байна. Үүнийг яаж арилгах гэж байгаа юм? Үүний аргачлалыг надад хариулж өгөөч. Дараа нь тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Б.Баярбаатар гишүүний асуултад хэн бэ? 5 номер хэн билээ? 5 номерын микрофоныг өгье.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам Ц.Эрдэнэбат. Гишүүний асуултад хариулъя.

Энэ улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөн дээр хэд хэдэн томоохон реформын асуудлууд орж ирж байгаа. Түүний нэг нь энэ төрийн албатай холбоотой.

Тэгээд энэ маань зайлшгүй орж ирэх хэд хэдэн шалтгаан байгаад байгаа юм.

Нэгдүгээрт нь, олон улсын технологийн шинэчлэлтэй холбоотойгоор нэлээд ажлууд хийгдэж байгаа. Тэгээд Ерөнхий сайдын албан даалгавраар ур чадварын шилжилтийн стратеги төлөвлөгөө боловсруулаад явж байгаа.

Мөн “Хүн цөмтэй”, “Хүн төв”-тэй бодлого гэж явж байгаа. Тэр нь юу гэсэн үг вэ гэхээр төрийн үйлчилгээг илүү иргэддээ ойрхон хүргэх ийм санаа. Үүнийгээ хийлгэхийн тулд цогцоор нь төрийн үйл ажиллагааны цогц шинжилгээ хийх, мөн процессыг нь дахин инженерчлэл хийх замаар бүтээмжийг сайжруулах гээд.

Тэгээд энэ цогц арга хэмжээний нэг хэсэг нь төрийн албан хаагчдын тоог бууруулах, мөн төрийн төсвийн урсгал зардлын хэмжээг бууруулж зохих түвшинд барих гэх мэтийн ажлуудыг хийхээр тусгагдаад явж байгаа.

Тэгээд энэ яагаад хийгдэх болсон үндэслэл нь болохоороо сүүлийн жишээлэхэд 10 жилийн хугацаанд төрийн улс төрийн алба, төрийн захиргааны алба, төрийн тусгай алба, төрийн үйлчилгээний албууд бүгд ингэж нэлээд их хэмжээгээр нэмэгдээд явсан байдаг.

Тэгээд энэ олон улсуудын сайн туршлага, жишгээр энэ ажил зайлшгүй хийгдэх нь зөв юм байна гэсэн ийм судалгаа гарч байгаа.

Тэгээд төрийн албаны процессын болон дахин реинженерчлэл хийсний үр дүн яг аль албан дээр хэдэн хувиар, хаана, яаж, одоо юу гэдэг юм цөөлөх энэ тоонууд нь илүү тодорхой болж нарийвчилж гарах юм.

Одоогийн түвшиндээ ер нь тэргүүлэх чиглэлийн бодлогод хэд хэдэн реформуудын нэг хэсэгт нь энэ ингээд ороод явж байгаа. Энэ дээр юу гэж ойлгож байгаа вэ гэхээр цомхотгоод, тэгээд тэр цомхотгосон хэмнэлтийг үлдсэн төрийн албан хаагчдын цалин, урамшуулал болон нийгмийн асуудлыг сайжруулахдаа нэмэх байдлаар явбал зөв гэсэн ийм бодлоготой төлөвлөгөө, судалгаа хийгдээд явж байгаа юм. Тийм.

Ц.Сандаг-Очир: Б.Баярбаатар гишүүн тодруулъя.

Б.Баярбаатар: Та бол эдийн засаг талаасаа ярьж байх шиг байна. Тийм ээ. Цалин мөнгийг нь хэмнээд, бусад руу нь явуулъя барья.

Инженерчлэлийг чинь би ойлгож байгаа. Анх төсөл дээрээ энэ чинь 15 хувь гэж явж байсан юм. Одоо тэр хувиар нь бодох юм бол бараг 8 мянган төрийн албан хаагч. Одоо болохоор 9 хувь. Энэ 9 хувь гэдэг тоог яаж гаргаж ирсэн юм? Та сая хэлчихлээ шүү дээ. Дахин инженерчлэлээ хийсний дараа яг тэр тоо нь тодорхой болно гэсэн мөртлөө одоо нэг ийм зохиомлоор 9 хувь гээд тоо оруулж ирээд тавьчихаж байгаа юм. Нэг.

Хоёрт, энэ дарга нараа цөөлөх асуудлаа яриач. Ер нь. Зүгээр нэг энгийн төрийн албан хаагч руу л орно шүү дээ. Одоо ингээд энэ чинь. Нэг амьдралаа залгуулаад явж байгаа төрийн албан хаагч руу л орно шүү дээ.

Тэгээд нэг их олон даргатай. Энд тэнд баахан дарга, даргын үүрэг гүйцэтгэгч тавьчихсан. Тэгээд тэд нарыгаа цөөлөх бодлого оруулж ирдэггүй юм уу? Тэгвэл. Тэгж байж энэ реформ болно шүү дээ.

Гуравт, үнэхээр энэ 5 мянган төрийн албан хаагчийг амьдралаас нь салгаад реформ чинь болчихно гэж бодож байгаа юм уу? Тэгээд.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номерын микрофон. Ц.Эрдэнэбат.

Ц.Эрдэнэбат: Тийм. Яг энэ давхардсан чиг үүрэг, удирдлагын шатлал өндөр энэ хэсэг дээр бас нэлээд ажлууд хийгдэхээр эхний урьдчилсан судалгаа явж байгаа.

Тэгээд энэ Бүтээмжийн хороо болон Засгийн газрын түвшний хэд хэдэн ажлууд, санаачилгууд явж байгаа. Тэгээд энэ хүрээнд судалгаанууд маань урьдчилсан судалгаа хийгдсэн. Яг эцэслэн тоог нь түрүүний миний ярьсан ажлууд хийгдэж байж яг хаана яг ямар түвшинд гэдэг нь гарах юм? Тэгээд тэр үед гишүүний саяын хэлснийг санал нийлж байна.

Ялангуяа тэр давхардсан чиг үүрэг, тэр удирдлага, түвшнийг бас нэлээд түлхүү харж одоо юу гэдэг юм судалгаагаа сайжруулах саналыг хүлээж авч байна. Тийм.

Ц.Сандаг-Очир: С.Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Хуралдаан даргалагч болон Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хорооны гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Би яг сая Б.Баярбаатар гишүүний асуусан асуулттай уялдуулсан байдлаар асуулт асууя гэж бодож байна.

228 мянга 820 мянган төрийн албан хаагч байгаа. Үүнээс

- 10 хувь нь төрийн захиргааны албан хаагч,
- 20 хувь нь төрийн тусгай,
- 68 хувь нь төрийн үйлчилгээний албан хаагч
- 1.7 хувь нь төрийн улс төрийн албан хаагч байгаа л даа.

Тэгээд сая орж ирж байгаа саналаар багш болон эмч нараас бусад гэж байгаа юм.

Тэгэхээр багш болон эмч нар төрийн үйлчилгээний албан хаагч нар дотроо байж байгаа юм л даа.

Тэгэхээр багцаа тоо бол 9 хувиар гэж тооцох юм бол лав багаар бодоход 8 мянгаас илүү байхаар ингэж тооцоо гарч байна гэж байгаа юм.

Тэгэхээр энэ тооцооллыг Та бүхэн сайн хийсэн байх. Хийх ч ёстой. Хийхгүйгээр үүнийг зүгээр санаагаараа тавьж тавьж болохгүй.

Сая Б.Баярбаатар гишүүний хэлсэнчлэн 15 хувь гэдэг бол ноднин ярьж байсан. Гэхдээ тэр бол гаднын олон улсын байгууллагын тайлан дээр байсан зүгээр жишиг байхгүй юу. Тухайн үед тэгж яригдаж байсан юм. Энэ төрийн

албан хаагчдыг нэг тийм 15 хувиар цөөлөх ёстой юм байна. Яагаад гэвэл тэр бол ер нь зүгээр ажиллах хүчний хувьтай харьцуулсан байдлаар ийм тоо байх юм гэж.

Тэгэхээр энэ 9 гэдэг хувийг Та бүхэн бидэнд нарийн танилцуулах ёстой. Тэгэхгүйгээр бид эндээс үүнийг шийдээд яваад байж болохгүй байх л гэж бодож байна л даа.

Түүнээс биш мэдээж хэрэг төрийн алба данхайж байна гэнэ. Ямар нэгэн газар давхцал байна гэнэ. Үүнийг бид зохистой бүтэцтэй байлгах ёстой гэдэг энэ зорилтыг бид сайшааж байгаа. Угаасаа тэгээд үүнийг чинь Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт оруулсан шүү дээ.

Тооцоолол хийх тийм Та бүхэн нарийн танилцуулаач гэдэг бидний хувьд асуудал тавьж байна. Та бүхэн дээр. Төрийн захиргаагаас хэчнээн нь чөлөөлөгдөх юм? Төрийн тусгай албан хаагч нь чөлөөлөгдөх юм уу? Төрийн тусгай албан хаагч нар чөлөөлөгдөх л юм байна шүү дээ. Одоо саяынхаар тэгж л ойлгож байна шүү дээ. Ийм нэгдүгээр асуултад Та бүхэн хариулаач.

Хоёрдугаарт, хэрвээ чөлөөлөх юм саяын чөлөөлөгдсөн албан хаагч нартай холбоотойгоор ямар нэгэн нийгмийн хамгааллын зардал гарах уу? Үүнийг Та бүхэнд тооцсон уу? Зүгээр нийгмийн даатгал төлж байгаа учраас, шимтгэл төлж байгаа учраас ажилгүйдлийн тэтгэмж аваад явна гэж үзэж байна уу, эсвэл тусдаа тэтгэмжийн асуудал байх юм уу? Үүнийг Та бүхэн тооцсон уу? Энэ чинь хүний асуудал байгаа. Сая Байнгын хорооны гишүүд хэлж байна шүү дээ. Төрийн албан хаагч нар гэдэг чинь цаанаа ар гэртэй, амьдралтай хүмүүс учраас энэ дээр Та бүхэн ямар тооцоолол хийж байна аа? Ямар зорилт тавьж байна гэж.

Гурав дахь асуудал. Хэрвээ чөлөөлөгдсөн байх юм энэ чөлөөлөгдсөн албан хаагч нарыг яах юм? Төрийн алба дотроо эсвэл өөр газар бид сэлгүүлэх юм уу, эсвэл хөдөлмөрийн зах зээл дээр ямар нэгэн ажилд байршуулах байдлаар ажил санал болгох юм уу? Үүнтэй холбоотой зохион байгуулалтын асуудлыг бодож байна уу гэсэн ийм гурван асуулт байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Ц.Эрдэнэбат: С.Зулпхар гишүүний асуултад хариулъя.

Бид нарын энэ бол урьдчилсан судалгаа, тооцоо. Тэгээд түрүүний хэлснээр энэ тооцооллоо улам сайжруулна. Одоогийн бид нарын 9 хувь ойролцоогоор 20 мянга 421 хүн болж байгаа юм.

Тэгээд яагаад зоригтойгоор 9 хувь гэж яваад байгаа вэ гэхээр түрүүний хэлснээр процессын дахин инженерчлэл хийнгүүт төрийн үйлчилгээг иргэддээ

ойрхон, автоматжуулах болон ажлуудыг хийхээсээ гадна төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, яг чаддаг экспертүүд, төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоодод нь шилжүүлэх нь зүйтэй юм гэж бодлого гарч байгаа.

Тэгээд энэ хүрээнд тэр төрийн цомхотголд орж байгаа төрийн албан хаагчид төрийн зарим чиг үүргийг тэр төрийн бус байгууллагаараа байдаг юм уу хийгээд явах, энэ нь илүү үр дүнд чиглэсэн, төрийн үйлчилгээг чанаржуулах талын ажил дээр зөв юм байна гэсэн бодлогын хүрээнд яригдаж байгаа юм.

Мөн дээрээс нь энэ дээр бас давхар судалгаа хийгдэж байгаа нь төрийн албан хаагчдыг цомхотголд орж байгаа тохиолдолд тэр дараагийн асуудлыг нь шийдэх, тэр нь ямар байдлаар шийдэх юм гэдэг дээр бид яг одоо судалгаанууд хийгдээд явж байна. Түүний нийт тооцоо нь дараагийн хэмнэлтээс үүдэх тэр тооноосоо илүүтэйгээр ер нь төрийн алба, төрийн чиг үүрэг нь үйлчилгээг тооноос илүү чанарт шилжүүлэх бодлогын хүрээнд явагдаж байгаа реформын арга хэмжээ юм шүү гэж тайлбарлах гэсэн юм. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Дутуу байна гэж байна. Гишүүн асуултад нь дутуу хариулаад байна гэж байна.

С.Зулпхар гишүүн тодруулъя.

С.Зулпхар: Ц.Эрдэнэбат дарга аа, би хоёр, гурав дахь асуултынхаа хариултыг Та бүхэн бодож байгаа болов уу л гэж асуугаад байгаа шүү дээ.

Энэ чөлөөлөгдсөн улсуудынхаа нийгмийн асуудлыг шийдэх юм уу, шийдэхгүй юм уу? Шийдэх бол яаж шийдэхээр Та бүхэнд төсөөлж байгаа юм гэдэг нэг ийм асуулт байгаа юм.

Энэ чинь 20-иод мянган албан хаагч чөлөөлөгдөнгүүт чинь үүний чинь цаана бас л мэдээж хэрэг тодорхой процесс явах ёстой шүү дээ. Энэ бол цаанаа зардал гарч л таараа. Энэ тооцооллыг Сангийн яам бүр нарийн хийж байгаа байх.

Гурав дахь нь, би асуугаад байгаа нь ингээд чөлөөлөгдсөн албан хаагчдаа яах юм? Энэ чинь одоо хүний нөөц шүү дээ. Энэ хүний нөөцөө байршуулахыг нь чөлөөтэй орхих юм уу, эсвэл ямар нэгэн байдлаар ахиад зохион байгуулалт хийх юм уу? Бодож байгаа юм байгаа байлгүй дээ. Тэгсэн мөртлөө бид сэлгүүлээд төрийн бус байгууллагууддаа зарим чиг үүргийг гүйцэтгүүлнэ гээд тэндээс ахиад хүний нөөц аваад л ахиад л тийшээ зардал шилжүүлэх гэж байгаа ийм зүйл та ярьж байгаа учраас үүнийгээ яаж бодож байгаа юм бэ л гэж байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Гишүүний асуултад ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Ц.Эрдэнэбат: Ц.Эрдэнэбат Эдийн засаг, хөгжлийн яам. Гишүүний асуултад нэмж тайлбарлая.

Тэр чөлөөлөгдөж байгаа төрийн албан хаагчид түрүүний хэлснээр тэр Төрийн зарим чиг үүргийг үргэлжлүүлээд хийхээр бодож байгаа. Түүнтэй холбогдуулаад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль яамнаас боловсруулж байгаа. Тэгээд энэ Төр, хувийн хэвшлийн ч түншлэлийн хуулийн гол агуулгуудынх нь нэг нь төрийн чиг үүргийг хувийн хэвслээр, эсвэл яг мэргэжлийн байгууллагуудаар, экспертүүдээр нь хийлгэдэг энэ тогтолцоо руу түлхүү явъя гэж энэ үзэл санааны хүрээнд хийгдэж байгаа.

Тийм учраас тэрийг нь чөлөөлөгдөж байгаа хүмүүс үргэлжлээд тэр одоо гэрээгээр байдаг юм уу, одоо тэр зохион байгуулалтад ороод үргэлжлээд ажиллах ийм бодлого цаашдаа явах юм.

Тэгэхээр 2026 оноос энэ том реформын хүрээнд ахиад хэлэхээр тэр процессын дахин инженерчлэл болон төрийн чиг үүргийн иж бүрэн дүн шинжилгээ хийж байж яг аль үйлчилгээ.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Гүйцээж хариулъя. Микрофон.

Ц.Эрдэнэбат: Аль үйлчилгээнүүдийг нь яг хувийн хэвшил рүү шилжүүлэх юм. Мэргэжлийг нь шилжүүлэх гэдэг тоо гарч ирж байж тэгээд түүнтэйгээ холбогдож реформын ажил маань давхар явах юм.

Мэдээж хэрэг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр ядуурлын 4 жилийн дотор 2 дахин бууруулна гээд заалт орсон. Мөн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө дээр ч гэсэн бид 2026 ондоо их амбицтайгаар ядуурлын бууруулахаар заалт явж байгаа. Энэ бодлогын хүрээнд мэдээж олон хүнийг ажилгүй болгоод байдаг ядуурлын эгнээ рүү шилжүүлж болохгүй.

Тийм учраас хажууд нь энэ бүтээн байгуулалтын томоохон төсөл, арга хэмжээнүүдийг ялангуяа орон нутагт чиглэж хийхээр төлөвлөгдөж байгаа.

Тэгэхээр яг энэ ингээд цогцоор нь харж байгаа. Ер нь цаашдаа бид энэ төрийн үйлчилгээг илүү чанартай байлгах үүднээс явах нь зүйтэй юм байна гэдэг ийм бодлогоор явж байгаа юм.

Тэр нийгмийн асуудал орхигдохгүй. Тэрийг түрүүний ярьсан яг энэ ажлыг хийхэд судалгаа хөтөлбөр.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Болсон уу? Э.Болормаа гишүүн асуултаа асууя.

Э.Болормаа: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Манай 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг бид хэлэлцэж байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний тухай хуулиараа нэг жилийн хөгжлийн төлөвлөгөө 5 жилийн үндсэн чиглэл дээрээ, дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөр дээрээ, тэгээд урт хугацааны хөгжлийн бодлого дээрээ суурилсан байх ёстой. Тэгж байж энэ маань бид хаашаа хүрэх гээд байгаа, тэрнийхээ замыг л аягүй нарийн гаргана шүү дээ.

Би жишээлбэл төрийн албаны шинэчлэл дээр тодорхой хэмжээгээр тоог нь багасгах, яг нарийн шириийнх нь яаж төлөвлөснийг мэдэхгүй ч гэсэн үүнийг дэмжиж байгаа. Яагаад вэ гэхээр дунд хугацааны зорилтот хөтөлбөр дээрээ буюу эдийн засгийн хөтөлбөр, “Шинэ сэргэлтийн бодлого” дээрээ төрийн бүтээмжийн сэргэлт буюу яг л энэ асуудлыг хөндсөн байдаг учир Та бүхэн түүнийхээ дагуу л энэ хөтөлбөрөө гаргаж байна гэж ойлгож байна.

Би аягүй тодорхой асуулт асууя гэж бодож байна. Тэгээд Хэрэг эрхлэхээс хүн байгаа юм уу? Хэрэг эрхлэхийн сайд нь байна уу? Уг нь яг энэ асуудлаа хариуцах ёстой хүн.

Нийтдээ бид 8 дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөтөлбөрийг гаргах ёстой. Дахиад давтаад хэлэхэд

- ▷ Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр,
- ▷ Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр,
- ▷ Эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр,
- ▷ Байгаль орчны зорилтот хөтөлбөр,
- ▷ Засаглалын зорилтот хөтөлбөр,
- ▷ Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр,
- ▷ Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр,
- ▷ Шинжлэх ухаан, технологийн зорилтот хөтөлбөр.

Одоогоор зөвхөн эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр буюу “Шинэ сэргэлтийн бодлого” гарсан байгаа. Бусад 7 дээр нь боловсруулах ажлын хэсэг ядаж байгуулагдсан уу? Энэ ажлууд эхэлсэн үү? Үүнийг Та бүхэн хийх ёстойг маш сайн мэдэж байгаа.

Тэгэхээр яг энэ дээр жишээлбэл би төсөөлөхдөө Хэрэг эрхлэхийн сайдын л гарын үсэгтэй ажлын хэсэг хийгдэх ёстой.

Тэгэхээр энэ асуудлаа хийж байна уу гэдгийг маш тодорхой асууя. Яагаад гэвэл сая яриад байгаа “Төрийн бүтээмжийн сэргэлт” энэ тэр чинь одоо энэ засаглалын зорилтот хөтөлбөр дээрээ гаргах ёстой байхгүй юу. Яг юу хийх гээд байгаа юм. Тэгж байж нарийн ширийн рүүгээ орохгүй болохоор. Нарийн ширийн

рүүгээ түрүүлээд орчхоод хаашаа явах гээд байгаа нь тодорхойгүй байхаар гишүүд иймэрхүү байдлаар асуух нь тодорхой байх.

Тэгэхээр яг энэ дээр хуулийн дагуу хийх ёстой ажлаа хийхээр ажлын хэсэг байгуулагдсан уу?

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Ц.Эрдэнэбат: Э.Болормаа гишүүний асуултад хариулъя. Ц.Эрдэнэбат

Тийм. Э.Болормаа гишүүн яг зөв асуулт асуулаа. Баярлалаа. Тэгээд улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө маань 5 жилийн үндсэн чиглэл дээр тулгуурлах ёстой.

5 жилийн үндсэн чиглэл маань 2020 оны 08 сарын 28-нд батлагдсан. Тэгээд энэ жил дуусаж байгаа.

Тэгэхээр энэ жил бид 5 жилийн үндсэн чиглэлээ боловсруулаад хийгээд эхэлсэн байгаа. Үүний нэгдүгээр хавсралт нь буюу хамгийн том хэсэг нь хөрөнгө оруулалтын хөтөлбөр гээд хэсэг. Энэ хэсэг дээр бид яамдтай ажиллаад эхний хувилбарууд маань гараад явж байгаа.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөгөө батлуулчихаад бид 5 жилийн үндсэн чиглэлээ батлуулах юм.

5 жилийн үндсэн чиглэл маань ахиад 10 жилийн зорилт хөтөлбөрүүд дээрээ тулгуурлах ёстой гэсэн хуулийн заалт байгаа. Тэгээд 10 жилийн зорилт хөтөлбөрүүдийг яам эхний хувилбарыг боловсруулаад өмнө нь Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн боловч батлагдаагүй байгаа. Тэгэхдээ түүнийгээ бид улам чанаржуулах ёстой гэдэг дээр тантай санал нийлж байна.

Яг Хэрэг эрхлэхийн түвшинд ажлын хэсэг байгуулагдаагүй байгаа. Бид эрдэмтэн судлаачтай хамтран ажиллаж байгаа. Эхний суурь судалгааны ажлууд нь хийгдээд эхэлсэн байгаа. 5 жилийн үндсэн чиглэлийн араас 10 жилийн зорилт хөтөлбөрүүдийг хийх юм.

Энэ нь ахиад “Алсын хараа”-г эхний 5 жилийг нь дүгнэх ажлын хэсэг Засгийн газрын түвшинд ажиллаж байгаа. Тэгээд энэ ажлын үр дүн, дүгнэлтийг бас нэлээд харах шаардлага байгаад байгаа. Тэгж байж хөгжлийн богино, дунд, урт хугацааны бодлогуудаа хооронд нь уялдуулах, илүү чанартай хийх ажлууд нь явж байгаа юм.

Товч хариулт нь болохоор Хэрэг эрхлэхийн түвшинд ажлын хэсэг хараахан гарч амжаагүй байгаа. Бэлтгэл ажлууд хийгдээд явж байгаа. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Зүгээр л асуултад хариулаарай. Гишүүдийн асуултын буруу, зөвийг ажлын хэсгийнхэн дүгнэдэг биш шүү дээ.

Э.Болормаа гишүүн тодруулъя.

Э.Болормаа: Би асуулт, санал хамт учир зүгээр тодруулга дээрээ санал хэлье гэж бодож байна.

Энэ 10 жилийнхээ төлөвлөгөөнийхөө ажлын хэсгүүдээ ядаж яаралтай байгуул гэж хэлмээр байна. Хэрэг эрхлэхийн төлөөлөл энд байвал. Энэ маань өөрөө сая Б.Баярбаатар гишүүн, С.Зулпхар гишүүний хэлдэг. Жишээлбэл, төрийн албаны шинэчлэл. Бид хаашаа явах гээд байгаа юм бэ. Шинэчлэл гэдгийг юу гэж ойлгоод байгаа юм. Зөвхөн тоо хууль гэх юм уу. Юу юм гэдэг чиглэл чинь 10 жил дээрээ гарч ирнэ.

Бараг 5 жилийн үндсэн чиглэлээсээ илүүтэйгээр. Яг дунд хугацааны зорилтот хөтөлбөр нь нөгөө “Алсын хараа” бид илүү бүтээмжтэй байна гэвэл дунд хугацаан дээрээ иймэрхүү байдалтай бүтээмжтэй ийм дүр зураг байна. Тэгж байж 5 жил нь яг ажлын төлөвлөгөө рүүгээ нэг жилийн ажлын төлөвлөгөө явах учир энэ хөгжлийн төлөвлөгөөний хэлэлцүүлгийн явцад ядаж ажлын хэсгээ байгуулаад ажилдаааа ор гэсэн саналыг хэлье.

Ц.Сандаг-Очир: Санал хэллээ. Ж.Баярмаа гишүүний асуулт.

Ж.Баярмаа: Асуулт гэж нөгөө зарчмын санал.

Ц.Сандаг-Очир: Саналаа ч хэлж болно. Та зарчмын зөрүүтэй санал гаргах гээд байгаа юм уу?

Ж.Баярмаа: Тийм.

Ц.Сандаг-Очир: Одоо асуулт явж байна. Асуулт санал. Тэгвэл Г.Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгэхээр үндсэн дөрвөн асуулт асуух гээд байна. Яг энэ дээр Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөн дээр төрийн албаны реформын хүрээнд үндсэндээ 2 ажил төлөвлөсөн байна л даа.

Нэгдүгээрт, төрийн байгууллагуудын чиг үүрэгт иж бүрэн шинжилгээ хийсний үндсэн дээр зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх замаар төрийн бүтээмжийг дээшлүүлнэ гэсэн байна.

Энэ нь бас нөгөө хоёр дахь асуудалтайгаа буюу тоо бууруулахтайгаа бас уялдаж орж ирж байна.

Тэгэхээр энэ сонирхож байгаа зүйл яг энэ хүрээнд жишээлбэл ямар чиг үүрэг нь хувийн хэвшилд шилжих боломжтой гэж харж байгаа юм бол оо? Энэ дээр бас урьдчилсан судалгаа хийгдсэн гэж байна л даа.

Тэгэхээр яг тэр урьдчилсан судалгааны хүрээнд жишээлэх юм бол иймэрхүү ажлуудыг хувийн хэвшилд шилжүүлснээрээ энэ 9 хувийн орон тооны цомхотгол буюу бууруулах энэ боломж бий болох юм гэдэг энэ нэг урьдчилсан судалгаагаар чинь ямар юм гарсан юм гэдэг дээр нэг мэдээлэл авмаар байна.

Үүнийг бид зайлшгүй бүтээмж ярьж байж орон тоо бууруулах тухай асуудал яригдах учраас энэ дээр суурь судалгаа, бүтээмжийн үнэлгээ хийгдсэн байгаа юм байна гэж ойлгож байна. Хоёрдугаарт.

Гуравдугаарт, төлөвлөгөөнийхөө 4.4-т “төрийн албаны хуулийн хэрэгжилтийг сайжруулсан байна” гэсэн байгаа. Тэгээд хүснэгтээр нь харах юм бол яг хоёр ажил байгаагийн хоёулаа яг адилхан төрийн албаны цахим системийг хиймэл оюун, технологийн дэвшилд суурилан хөгжүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлэх гээд. Энэ нь хоёр үзүүлэлтээр хоёулан дээр нь ороод ирсэн байхгүй юу. Тэгэнгүүт энэ дээр арга хэмжээний хэрэгжилт гээд 500 сая, дэд бүтцийн шинэчлэл, сайжруулалт, нэвтрүүлэлт гээд 500 сая. Ингээд нийт 1 тэрбумын ажил тавигдаад байх шиг байгаа юм.

Тэгэхээр ялгаа нь юу юм бэ? Арга хэмжээний хэрэгжилт гэдэг нь 100 хувь байх гээд байгаа 500 саяар яг юу хийх гээд байгаа юм? Дэд бүтэц, шинэчлэл, сайжруулалт, нэвтрүүлтийг бол ойлгоод байна.

Тэгэхээр үүнээс тусдаа ялгаатай нь юу байгаа юм бол гэдэг гуравдугаар асуулт байна.

Дөрөвдүгээрт, 4.5 дээр байгаа төрийн үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн түвшнийг нэмэгдүүлсэн байна гэж байгаа юм.

Тэгэхээр энэ дээр яг юуг хийж. Одоо жишээлэх юм бол

- ▶ төрийн үйлчилгээний процесс, дахин инженерчлэл хийх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх,
- ▶ төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудын өргөдөл гомдлын шийдвэрлэлт, хяналт тавих,
- ▶ нэгдсэн цогц систем нэвтрүүлэх гээд ийм үндсэндээ гурван ажил тавьчихсан байгаад байгаа юм л даа.

Тэгэхээр энэ гурван ажлын хүрээнд буюу яг ямар байдлаар тэр төрийн үйлчилгээний талаарх тэр сэтгэл ханамжийн түвшин нэмэгдсэн байх юм бэ гэдгийг тодруулж асуумаар байна.

Одоо энэ суурь түвшин жишээлбэл 2, зорилтот түвшин 3 гэсэн байгаа байхгүй юу. Тоогоор гээд. Яг энэ талаар арай илүү дэлгэрэнгүй мэдээлэл авмаар байна.

Ц.Сандаг-Очир: Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Ц.Эрдэнэбат: Г.Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Ц.Эрдэнэбат Эдийн засаг, хөгжлийн яам.

Одоо яг төрийн зарим чиг үүрэг **e-mongolia** болон зарим цахим автоматжуулалтын хүрээнд хийгдээд явж байгаа. Энэ ажил маань улам сайжрах юм. Энэ хүрээнд бид нэлээд судалгаа хийж байгаа. Тэгээд судалгаа нь бас яг процессын дахин инженерчлэл болон түрүүний хэлсэн төрийн чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж байж бүр илүү тодорхой болох юм билээ.

Энэ хийгдсэний үр дүнд эрэмбэлээд, үүний цаад үндсэн үзэл санаа нь юу байна гэхээр иргэд нь төр дээрээ ирж үйлчилгээ авдаг биш. Тухайлбал, төрөнгүүтээ төрсний гэрчилгээг авахын тулд нэг төрийн байгууллага дээр ирдэг биш, төр нь аль болохоор иргэндээ очиж үйлчилдэг үзэл санааны хүрээнд энэ ажлууд нь цогцоор нь хийгдэх юм.

Тийм учраас энэ бол нэлээд тооцоо судалгаа хийж байж, нэлээд олон талаас нь харж байж хийх ёстой гэсэн байдалтай байгаа. Өмнө ч үндсэндээ энэ чиглэлээр хийгдэж байсан судалгаанууд байдаг юм байна лээ. Мэдээж хэрэг энэ нь ахиад буцаад бүтээмжийг сайжруулах, төрийн үйлчилгээг илүү чанартай, шуурхай, төсвийн хүрээнд нь, иргэддээ үйлчлэх гэсэн агуулгын хүрээнд энэ ажлууд нь төлөвлөгдөөд явж байгаа юм. Тийм.

Ц.Сандаг-Очир: Тодруулах уу? Хариулт дутуу байна гэж үзэж байна. Тодорхой хариулъя. Асуултад. Хариулт хангалтгүй байна гээд байна. Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Ц.Эрдэнэбат: Тэгээд энэ хүрээнд нэлээн хэдэн ажлууд хийгдэж байгаа. Түүний нэг нь **“Хөгжлийн нэгдсэн мэдээллийн сан”** бий болгохоор Засгийн газрын түвшинд ажлын хэсэг гараад ажиллаж байгаа.

Мөн **“төлөвлөлт”**, **“төсөвлөлт”**, **“хяналт, үнэлгээ”**-ний нэгдсэн платформ байгуулахаар Засгийн түвшинд бас ажлын хэсэг гараад Сангийн яам, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар болон манайх хамтраад ажиллаад явж байгаа.

Тэгэхээр эдгээр ажлууд хийгдсэнээр төрийн ажил автоматжих, эсвэл түрүүний хэлдгээр илүү чанартай хүргэх энэ хүрээнд саяын нэр бүхий ажлууд тусгагдаад явж байгаа юм.

Ингэснээр саяын хэлсэн зорилтот түвшиндээ хүрэхээр энэ ажил тусгагдсан явж байгаа. Төрийн реформынхоо хүрээнд орсон ажлууд гээд. Би асуултыг чинь буруу ойлгочхов уу? Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Тодруулъя. Г.Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Төрийн албаны зөвлөлөөс байгаа билүү? Гол нь энэ дээр чинь би яг Төрийн албаны зөвлөл дээр хариуцсан ажил байгаа шүү дээ. Тэгээд яг адилхан хоёр ажил байгаа. Түүн дээр нэг нь 500 саяар, нөгөөдөх нь бас 500 саяар гээд байгаа юм.

Тэгэхээр яг энэ хоёрын ялгаа нь юу юм бэ?

- Нэгд, арга хэмжээний хэрэгжилт.
- Хоёрт, дэд бүтцийн шинэчлэл, сайжруулалт, нэвтрүүлэлт гэсэн.

Хойд талд нь байгаад байгаа. Үүний ялгааг шууд хэлээд өгөөч гээд байгаа.

Хоёрдугаарт нь, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас байгаа юу? Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар чинь өөрөө бас төлөвлөгөө дээрээ тавьчихаад байна шүү дээ. Энэ “үйлчилгээний иргэдийн сэтгэл ханамжийн түвшнийг сайжруулна” гээд.

Энэ чинь бид нэг ийм 5 жил, 10 жилийн тухай биш 1 жилийн тухай ярьж байгаа учраас яг үүний цаана ямар ажил хийгдэх гээд байгаа юм, яг юунд энэ мөнгийг зарцуулна гээд тавьчихсан юм бэ гэдэг чинь энэ хариуцсан газрууд нь уг нь гаргаж ирээд тавьсан гэж ойлгоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ хоёр асуултынхаа хариултыг би ерөөсөө авч чадсангүй л гэж байна.

Ц.Сандаг-Очир: Гишүүний асуултад дахиад нэг тодруулаад хариулаадхаач. Төрийн албаны зөвлөл. Хэн бэ? Ажлын хэсгийн 6 номерын микрофон.

В.Жавзан Г.Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Төрийн албаны зөвлөл В.Жавзан.

Энэ цахим системийг хөгжүүлэх ажил дээр бид 13 модуль хөгжүүлэхээр Төрийн албаны зөвлөл төлөвлөөд ажиллаж байгаа. Өнөөдрийн байдлаар 8

модулийг хөгжүүлсэн. Энэ дээр нийт 226 мянган төрийн албан хаагчийн цалингийн систем, ажиллах нөхцөл, сонгон шалгаруулалт, бүх асуудлыг цэгцэлсэн байгаа учраас одоо энэ дээр бол яах вэ арга хэмжээ гээд хоёр давхардсан юм шиг харагдаж байгаа боловч тус тусад нь үндсэндээ дэд бүтэц хөгжүүлэлт дээр 1 тэрбум төгрөг гэж төлөвлөсөн байгаа.

Ц.Сандаг-Очир: Ахиад тодруулах уу? Г.Уянгахишиг гишүүн ахиад тодруулъя. 1 минут.

Г.Уянгахишиг: Үгүй энэ дээр чинь тэгээд саяны хэлж байгаа нь бол тэгээд арга хэмжээний хэрэгжилт гэж юм бол байхгүй. Дэд бүтцийн шинэчлэлт, сайжруулалт, нэвтрүүлэлт дээр тэрбум төгрөг байгаа гэж ойлгох юм байна. Тийм үү? Тэгвэл яах гэж ингэж хоёр хувааж оруулж ирсэн юм бэ гэдэг асуулт байна.

Хоёр дахь асуулт. Одоо Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар байхгүй байгаа болохоор түүн дээр хариулт хэлэхгүй юм байна гэж ойлголоо.

Тэгээд ер нь төлөвлөлтийн яг энэ шалгуур үзүүлэлт буюу үнэлгээний 3 дугаар хавсралт байгаа шүү дээ. Тэгэнгүүт 3 дугаар хавсралт дээр миний асуугаад байгаа 4.4, 4.5.5 хоёр яг яаж үнэлэгдэх юм гэдэг юмыг би олж харж чадсангүй. Тэр нь хаанаа бичигдсэн байгаа юм?

Тэгээд ер нь зүгээр үг хэлэхэд хөгжлийн төлөвлөгөө дээрээс харахаар тоонууд нь зөрүүтэй. Тэгээд жишээлэх юм бол одоо энэ 1.7.3 дээр байгаа байхгүй юу. Түрээсийн орон сууцын тоо нэмэгдсэн байх гэдэг дээр 1500 орон сууц гэсэн мөртлөө төсөв нь.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 6 номерын микрофон. Хариулах хүн байна уу? Хэн хариулах юм? Ажлын хэсгийнхээ. Төрийн албаны зөвлөл, Эдийн засаг, хөгжлийн яамныхан.

Гишүүдийн асуултад хэн хариулах юм бэ? Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Ц.Эрдэнэбат: Ц.Эрдэнэбат Эдийн засаг, хөгжлийн яам. Гишүүний асуултад нэмж хариулъя.

Та 1.7.3 дээр “түрээсийн орон сууцын тоо нэмэгдсэн байна” гэдгийг хэлсэн байх. Тэгээд энэ дээр хамрагдсан өрхийн тоогоор уг нь энд тусгагдаад явсан байгаа.

Энэ дээр хэрэв сайжруулах санал байвал бид бас энэ хариуцсан яамтай нь яриад энэ дээр анхаарч ажиллая. Тийм.

Ц.Сандаг-Очир: Үнэхээр гишүүдийн асуултад хангалтгүй хариулж байна шүү. Дандаа дутуу. Асуусан 4, 5 гишүүн бүгд сэтгэл дундуур. Хариултаа бүрэн дүүрэн авч чадахгүй байна гэж хуралдаан даргалагчид гомдол тавьж байна. Нэг аргацаасан, судалж байна, хариулт тодорхой хэлье гээд. Хэзээ нь хэлэх юм. Та бүхэн чинь ажил хариуцаж байгаа улсууд шүү дээ.

Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөө оруулж ирчхээд явж байгаа улсууд шүү дээ. Энэ төлөвлөгөө юунд үндэслэж, юунд суурилж энэ тооцоо судалгаануудыг гаргаж ирсэн юм бэ гэдгээ Та бүхэн хамгаалж чадахгүй юм бол яах гэж Төрийн байгуулалтын байнгын хороогоор энэ асуудлуудыг оруулж ирж байгаа юм. Гишүүдийн асуултад хариулж чадахгүй юм бол яах гэж энд о сууж байгаа юм. Тооцоо судалгаа, үндэслэл муутай хариултууд хэлээд байна.

Би бас хувиараа асуулт асууя. Төрийн албаны зөвлөлөөс хариулж өгөхийг хүсье.

Одоо жишээ нь наад ажлын хэсэг дотор чинь л гэхэд л даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч 5 хүн сууж байгаа байхгүй юу.

Ер нь түрүүн Э.Болормаа гишүүний тэр яриад байгаа асуудлууд чинь углуурга нь энэ байхгүй юу. Төрийн албаны шинэчлэл гэдгээ Та бүхэн юу гэж хараад байгаа юм. Зүгээр одоо байгаа тоог цөөрүүлэхээр төрийн албаны шинэчлэл болно гэж ойлгоод байгаа бол энэ бол андуурал, эндүүрэл.

Ирэх жил Та бүхэн 9-өөс 10 хувиар бууруулахаар оруулж ирж байх шиг байна. Мөрөөрөө ажлаа хийж байгаа, ажилдаа түүртээд ажлынхаа ачаалалд дарагдаад байж байгаа төрийн албан хаагчдын юуг нь цомхотгох гээд байгаа юм. Харин Та бүхэн энэ төрийн албаны ангилалд орохгүй байгаа төрийн өмчийн компаниуд дээр өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа, бараг 5, 6 төрийн албан хаагчийн цалинг нэг хүн авч байгаа энэ төрийн өмчийн компаниуд дээр өндөр цалин авч байгаа энэ хэрэгтэй хэрэггүй хүнд зориулагдсан орон тоонуудыг та нар бууруулна, цөөрүүлнэ гэж Эдийн засаг, хөгжлийн яам чинь оруулж ирэх ёстой юм биш үү.

Тэгэхгүйгээр зүгээр мөрөөрөө ажлаа хийж байгаа, өдрийнхөө ажилд дарагдаад, иргэдийнхээ асуудалд дарагдаад байж байгаа, тэгээд 1 сая 200 мянган цаасны цалин аваад сууж байгаа төрийн албан хаагчдыг 10 хувиар цомхотгоно гэж оруулж ирж байгааг Та бүхэн юу гэж үзээд байгаа юм бэ? Энэ чинь ямар тооцоо судалгаа нь хийгдсэн юм бэ?

Тэр төрийн өмчийн компаниуд дээр өдрөөс өдөрт 3 намын төлөөлөл гээд. Энэ төрийн өмчийн компаниуд чинь бөөн алдагдал гээд л яриад л, учирлаад л ийм байгаа хэрнээ дээр нь болохоор хүнд зориулагдсан хүн орон тоо нэмэх болохоор 3 БЭТ_[бүрэн эрхт төлөөлөгч] гээд л томилогдоод л л яваад байгаа шүү дээ. Үүнийг юу гэж үзэж байгаа юм? Үүнийг яах юм? Ингээд яваад байх юм уу?

Энэ чинь нэг карманаас, татвар төлөгчдийн карманаас л гарч байгаа шүү дээ. Тэгээд ангилалд нь орохгүй болохоор яваад байж болох юм уу? Энэ дээр ямар тооцоо, судалгаа хийгдсэн юм. Өнөөдөр хэчнээн орон тоо энэ төрийн өмчийн компаниуд дээр нэмэгдээд, хүнд зориулагдсан орон тоонууд нэмэгдээд байна. Энэ дээр нэг хариулт өгөөч.

Тэр Төрийн албаны зөвлөлийнхөн. Одоо байгаа сонгуулийн хар машин, Сонгуулийн хорооны хар машины чинь хугацаа бас дуусаж байгаа юм шиг юм яригдсан байна лээ. Үүнийг шинэчлэх асуудлыг төсөв хөрөнгөд тавиулах асуудлыг Сонгуулийн хорооноос саналаа тавьсан энэ хөгжлийн төлөвлөгөөнд ерөөсөө ороогүй байна гэсэн асуудлыг яриад байгаа.

Одоо ингээд л 2027 он, 2028 оны сонгууль чинь хаяанд ирлээ. Энэ машин чинь өөрөө хугацаа нь дууссан. 10 жилийн хугацаатай байдаг гэсэн байх аа. Ингээд дуусаж байгаа юм яриад байгаа юм байна. Үүнийгээ шинэчлэх асуудлыг нь хэзээ яаж төлөвлөгөөнд оруулж төсөв хөрөнгийг нь баталж өгөх юм бэ? Энэ хоёр асуултад хариулт өгөөч. Хэн хариулах вэ?

Тэр араас Сонгуулийн ерөнхий хорооны хэн билээ? Дарга нь Д.Баяндүүрэн дарга. Ажлын хэсгийн 7 микрофон. 1 номер дээр гар өргөсөн үү? Дараа нь. 7 номерын микрофон.

Д.Баяндүүрэн: Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Д.Баяндүүрэн.

Сонгуулийн санал тоолох төхөөрөмжийг 2012 онд авсан. Үүнээс хойш 13 жилийн хугацаа өнгөрч байна. Санал тоолох төхөөрөмжийн хувьд Америкийн Нэгдсэн Улсын “Dominion **Voting**” гэдэг компанийн төхөөрөмжийг авсан байгаа.

Бид нараас өмнө энэ санал тоолох төхөөрөмжийг хэрэглэж байсан Филиппин Улс гэхэд санал тоолох төхөөрөмжөө одоо сая болсон сонгуулиар 3 дахь удаагаа сольчихоод байгаа юм.

Бид нарын хувьд энэ санал тоолох төхөөрөмжөө солиогүй явж байгаа. Ер нь ашиглалтын хугацааны хувьд дууссан.

Нийтдээ 3 мянган төхөөрөмж байгаа. Энэ 3 мянган төхөөрөмжөөс 500 ширхэгийг өнгөрсөн онд авсан. Одоо 3 мянган ширхэг төхөөрөмж нэмж авах ийм зайлшгүй шаардлага байгаа.

Бид хөгжлийн төлөвлөгөөнд саналаа өгөхдөө энэ саналыг Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлсэн байгаа. Төлөвлөгөөнд тусаагүй явж байна. Тэгэхдээ бид нарт 2026 оны төсөвт тусгах зайлшгүй шаардлага байгаа. Яагаад гэх юм бол 2027 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль болно. 2028 онд Улсын Их Хурлын сонгууль болно.

Тэгээд энэ гэрээ хэлцэл байгуулахтай холбоотой болон тээвэр ложистик, нийлүүлэлтээ тооцох юм бол нэг жилийн хугацаа энэ шинэчлэлийн ажилд зайлшгүй шаардлагатай.

Тийм учраас 2026 оны төлөвлөгөөнд тусгах боломж байвал тусгаж өгөөч. Ийм боломж байхгүй бол бид төсвийн хүрээний мэдэгдэл болон 2026 оны улсын төсөвт тусгуулах энэ саналыг Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхэм гишүүд Та бүхэн анхааралдаа бас авч өгөөч ээ гэж ингэж хүсэж байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Нэг дэх асуултад хэн хариулах юм? Эдийн засаг, хөгжлийн яамнаас хариулъя. Ажлын хэсгийн 5 уу?

Та бүхэн Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө оруулж ирчхээд танилцуулагдаад хамгаалж байгаа улсууд шүү дээ. Хариулах хүн байна уу? Тооцоо судалгаа хийгдсэн юм байна уу? Яах юм гишүүд ээ. Энэ асуудлыг. Та бид асуусан болдог. Асуултад хариулсан болдог. Бие биеэ аргалаад өнгөрөх юм уу, яах юм. Хойшлуулах юм уу. Ийм одоо хоёрын хооронд хариулт аваад сууж байна. Үндсэндээ гишүүдийг аргалаад л өнгөрч байна шүү дээ.

Тэгээд оруулж ирсэн юмаа хамгаалж чадахгүй байна шүү дээ. Бодитой хариулт тайлбарыг өгч чадахгүй байна шүү дээ. Яах юм. Гишүүд ээ. Бид илүү олон юм асуугаагүй шүү дээ. Яг Төрийн байгуулалтын байнгын хороонд харьяалах, хамаарах төрийн албатай холбоотой асуудлуудаа, төрийн албаны бүтэц, зохион байгуулалт, шинэчлэл, тэр цомхотгол юмтай чинь холбогдуулж асуугаад байна шүү дээ. Гишүүд. Тэгтэл зөвхөн энэ сэдэвтэй холбоотой асуудлуудыг Та бүхэн бодит хариултыг өгөхгүй байна шүү дээ. Яах юм, гишүүд ээ? Энэ асуудлыг. Яамаар байна. Ахиж хойшлуулах уу? Одоо энэ чинь маргааш чуулганаар ороод явна биз дээ? Хоёр дахь хэлэлцүүлэг. 4 дэх өдөр. Тийм ээ. Хоёр дахь хэлэлцүүлэг үү? Хоёр дахь хэлэлцүүлэг. Харин тийм. Энэ чинь одоо юу гэж санал өгөх юм?

5 номерын микрофоны хариултыг сонсьё.

Ц.Эрдэнэбат: Төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулахтай холбоотойгоор энэ төрийн өмчийн компаниудын нэлээд шинэчлэлүүд одоо хийгдээд явж байгаа.

Энэ жилээс авхуулаад “Эрдэнэс Монгол”, “Эрчис Монгол” гэх мэтчилэнгийн компаниудынх нь одоо юу гэдэг юм, эхний ажлууд нь хийгдээд одоо энэ бид нарын судалгаагаар дараагийн түвшинд энэ 99 байгууллагуудын нийт орлого, зардал, цэвэр ашгийн алдагдлын хэмжээг энэ дээр бүтээмжийн сайжруулалт хийхээр тусгагдаад явж байгаа.

Одоогийн байдлаар эндээс 15 хувиар бууруулахад 2.5 их наяд төгрөгөөр бууруулах ийм тооцоо гараад явж байгаа. Мөн цаашдаа 30 хувиар нэмэгдүүлэхээр 1.4 их наяд төгрөгөөр нэмэгдэж, нийт 6.5 орчим их наядын хэмнэлт гэх үү, сайжралт гарна гэж тооцоо, судалгаа хийгдээд явж байгаа. Тийм.

Ц.Сандаг-Очир: Гишүүд 2026 оны Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөнөөс асуулт асууж, санал хэлж дууслаа.

Одоо зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалгана. 2 санал байгаа юм байна. Тийм ээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого гэсэн 4 дүгээр тэргүүлэх чиглэлд доор дурдсан агуулгатай 4.1.5, 4.1.6 дахь заалтыг тус тус нэмэх:

“4.1.5.даргын эрх мэдлийг баталгаажуулсан байгууллагын хуулийг өөрчилж, иргэнд үйлчлэх албаны хууль болгон шинэчлэх ажлыг эрчимжүүлнэ;

4.1.6.төрийн албан хаагчийн улс төрийн болон удирдлагын хууль бус шийдвэр, аливаа дарамт шахалтаас ангид байлгах эрх зүйн шинэчлэл хийнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа. Ж.Баярмаа гишүүн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоо нэг танилцуулж, тайлбарлах уу? Ж.Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Яагаад ийм санал оруулж байна гэхээр хамгийн нэгдүгээрт энэ өөрөө Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд орсон байгаа юм. Хөтөлбөрт.

4.2.3.4, 4.2.3.6-д яг энэ агуулгаараа шахам даргын эрх мэдлийг баталгаажуулсан байгууллагын хуулийг халж, иргэнд үйлчлэх албаны хууль болгоно гээд бүр орсон.

Нөгөөдөх нь яг төрийн албан хаагчийг улс төрчийн болон удирдлагын хууль бус шийдвэр, аливаа дарамт шахалтаас ангид байлгана гээд. Ингээд томьёологдоод манай Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орсон байгаа юм. Мөртлөө одоо энэ чинь хоёр дахь жилийн төлөвлөгөө болж байна шүү дээ. Гэтэл хоёр дахь жилийнхээ төлөвлөгөөнд энэ заалтаа оруулахгүй юм бол бид ер нь энэ үр дүнд хүрч чадах эсэх чинь тодорхойгүй болж байгаа юм.

Тийм учраас хамгийн нэгдүгээр үндэслэл энэ мөрийн хөтөлбөрт тусгасан зүйлээ одоогоос оруулаад хэрэгжүүлэх ажлаа эхлээч ээ. Тэгэхгүй бол энэ чинь амжихгүй шүү гэдэг үндэслэл байна.

Мэдээж ер нь манай энэ хуулиуд даргын эрх мэдлийг л аль болох хамгаалсан, бэхжүүлсэн нэг ийм чиглэл рүү байдаг. Гэтэл яг нөгөө иргэдийгээ хамгаалсан гэдэг дээрээ сул мөртлөө эсрэгээрээ иргэдийг дандаа хариуцлагажуулсан энэ чиглэл рүүгээ байдаг. Тийм ч учир энэ заалтыг Засгийн газрын мөрийн хөтөлбөрт оруулсан байгаа юм.

Ер нь хуулийн засаглал гэдэг чинь, хууль гэдэг чинь ер нь яагаад үүссэн гэхээр төрөөс, төрийн хүнд суртал, төрийн энэ эрх мэдлээс иргэдийг хамгаалах гэж л хуулийн засаглал оршиж байгаа шүү дээ. Бүр цаад философи нь. Гэтэл манай хуулиуд эсрэгээрээ дарга ангийг хамгаалсан энэ чиглэл рүү орсон байна.

Тийм учраас энэ дээр зарчмын өөрчлөлтийг оруулах шаардлагатай байна. Тэгээд энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлээсэй гэж.

Хоёр дахь тэр төрийн албан хаагчийг улс төрчдийн хууль бус шийдвэр, дарамтаас хамгаална гээд. Энэ аягүй чухал байгаа юм. Тэгээд бид мэднэ шүү дээ. Одоо ерөөсөө Хүний эрхийн Үндэсний Комисс дээр байгаа гомдлуудын ихэнх нь ерөөсөө дандаа төрийн албан дахь дарамт шахалт гэж байгаа юм.

Тэгэхээр энэ дарамт шахалт юу байна гэвэл мэдээж дандаа хууль бус шийдвэр гаргуулах гэдэг байх. Ингэж явсаар сүүлдээ энэ чинь хайнга хандсан, ажилдаа хариуцлагагүй хандсан болж хувираад л нөгөө муу төрийн албан хаагчид чинь байнга нэг хариуцлага хүлээдэг нэг ийм юм руу орчихсон юм.

Дээрээс нь энэ чинь нөгөө шүгэл үлээх боломж байхгүй. Нөгөө Шүгэл үлээгчийн тухай хууль энэ тэрээ бид ерөөсөө ярилцаа ч үгүй, оруулаа ч үгүй явж байна.

Тэгэхээр төрийн албан хаагчдад дээрээс нь ногдуулж байгаа тэр хууль бус шийдвэрүүдийг биелүүлэхгүй байх. Түүгээрээ бас хамгаалагдах эрх зүйн орчин нь бүрдээгүй гэж үзээд энд угаасаа оруулсан гэж бодож байгаа.

Тэгэхээр үүнийгээ оруулж өгөхгүй бол ерөөсөө манай төрийн албан хаагчид чинь тэгээд дарга ангиасаа айгаад хууль бус шийдвэрийг нь биелүүлэх ийм нэг ийм дарамт нь байдаг юм.

Тэгэхээр энэ ажлаа эхлүүлээч ээ гэсэн ийм л зорилгоор энэ зарчмын зөрүүтэй саналыг оруулж байгаа юм. Тэгэхгүй бол одоо хоёр дахь жил нь өнгөрөх гээд байна.

Ц.Сандаг-Очир: Засгийн газрын үйл ажиллагааны 4 жилийн хөтөлбөрт туссан асуудал нь тухайн жилийн төлөвлөгөөнд ороогүй байна.

Тийм учраас одоо хугацаа алдах учраас ирэх жилийн төлөвлөгөөнд оруулах ёстой гэж зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргасан. Зарчмын зөрүүтэй саналын томьёоллийг уншиж уншиж танилцуулсан байгаа. Санал хураалт явуулахад яахаар байна? Бүгд дэмжиж байж л нэг юм давах юм шиг байна. С.Зулпхар гишүүн Боловсролын яаман дээр хурал удирдах ажилтай байна. О.Номинчимэг гишүүнийг дууд. Санал хураалт. Гишүүдээ дуудаач.

Одоо ер нь тэгээд О.Алтангэрэл сайдын санал нэг байна. Тэгээд байгаа гишүүдийнхээ хүрээнд тэгээд саналаа хураагаад л дэмжвэл дэмжээд л, дэмжигдэхгүй бол унаад л явахаас өөр аргагүй шүү дээ. Одоо тэгээд яах юм тэгээд.

Тэгээд Засгийн газар оруулж ирсэн асуудлаа дэмжүүлэх гэж байгаа бол Засгийн сайд нар нь өөрсдөө байгаад хуралдаа ороод явна биз. Одоо тэгээд унахаараа тэгээд яадаг юм. Тэгээд унаад л явахаас одоо өөр яах вэ дээ одоо тэгээд. Тэгээд байсан гишүүд нь өөрсдөө чадлаараа л зүтгэж байна. Тэгээд байхгүйнууд нь одоо тэгээд ажлаа унагаад л явахаас өөр одоо яах вэ дээ.

Санал хураалт. Зарчмын зөрүүтэй саналаар. Түрүүн уншсан. Дахиж унших шаардлагагүй биз дээ. Ж.Баярмаа гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт.

О.Алтангэрэл сайд горимын санал.

О.Алтангэрэл: Төхөөрөмж ажилласангүй.

Тэгэхээр саяын санал хураалтыг хүчингүй болгож дахин санал хураалт явуулж өгнө үү.

Ц.Сандаг-Очир: О.Алтангэрэл сайдын гаргасан горимын саналын дагуу саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт.

Санал дэмжигдсэнгүй. Одоо л явъя гэсэн яасан. Тийм үү?

Хоёр дахь зарчмын зөрүүтэй саналын томьёололыг уншиж танилцуулъя.

2.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого гэсэн 4 дүгээр тэргүүлэх чиглэлд доор дурдсан агуулгатай 4.4.4 дэх заалтыг нэмэх:

“4.4.4.төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйлдлээс хохирсон иргэд, бизнес эрхлэгчдийн хохирлыг шуурхай барагдуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх.”

Гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор Ж.Баярмаа гишүүн тайлбарлая.

Ж.Баярмаа: Энэ дахиад л нөгөө манай Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт байгаа юм. 4.2.1.10-д. Яг төрийн байгууллага, албан тушаалтны буруу буруутай үйлдлээс хохирсон иргэд, бизнес эрхлэгчдийн хохирлыг барагдуулах механизмыг бүрдүүлнэ гээд тусгасан мөртлөө одоо хоёр дахь жилдээ орж байхад энэ асуудлыг ерөөсөө оруулж ирэхгүй байгаа юм.

Энэ бол одоо маш чухал. Ерөөсөө бүхэлдээ энэ чинь бизнес эрхлэгчдээ дэмжье гэдэг энэ манай бүр Засгийн газрын, Улсын Их Хурлын концепц яваад байгаа.

Тэгэхээр энэ ингэж хохирч байгаа бизнес эрхлэгчид, иргэдийн энэ хохирлыг барагдуулах тал дээр асар дутагдалтай байна.

Зүгээр над дээр аягүй их өргөдлүүд ирээд байгаа юм. Тэгээд зүгээр жишээ хэлэхэд энэ Уламжлалт анагаах ухааны клиник судлалын төв гээд. Тийм ээ. Энэ төвийн нэг ийм сувилал байх шиг байгаа юм. Зүгээр би жишээ дурдаж байна шүү дээ. Тэгээд энэ сувилал болохоор менежментийн хувьчлалаар тэр эздүүд нь авсан. Тэгээд шүүхийн гурван шатны шийдвэр нь гарчихсан яваад байдаг юм билээ. Атал нийслэл тэр сувилалыг нь булааж аваад нийслэл өөрөө сувилал ажиллуулна гээд авсан.

Тэгэхээр бүр шүүхийн шийдвэртэй асуудлыг хүртэл одоо төр маань булааж аваад өөрсдөө сувилал ажиллуулна гээд яваад байхаар нөгөө бизнес эрхлэгчдээ дэмжинэ гэсэн юм нь хаана байгаа юм бэ гэдэг асуудал.

Дахиад ТҮЦ-үүдийн асуудал орж байгаа. ТҮЦ ч гэсэн бизнес эрхлэгчид. Тэгээд ТҮЦ-үүдийн нэг ТҮЦ-ийг нь хурааж аваад л нэг буцааж тавиад л ингээд байна гэдэг чинь бас энэ ТҮЦ эрхлэгчдийн эрх ашгийг маш ноцтойгоор зөрчиж байгаа юм.

Сүүлд О.Алтангэрэл сайдын Засгийн газрын хуралдаан дээр ярьсан яриа байгаа. Сүүлийн 5 жил гэхэд төрийн албан хаагчдын учруулсан хохирол 60 гаруй тэрбумд хүрсэн гэж байгаа юм. Төрийн байгууллага, албан тушаалтнуудын буруутай үйлдлээс болж хохирсон хохирол 60 гаруй тэрбум. Тэгээд энэ ерөөсөө маш тийм удаан явцтай байдаг. Бараг явдаггүй шахам.

Тийм учраас угаасаа манай Засгийн газар маань мэдээд уг нь бас хөтөлбөртөө оруулсан юм байна л даа. Тэгээд даанч үүнийгээ яагаад хаячхаад байгааг нь мэдэхгүй байна. Тийм учраас үүнийг оруулмаар байна.

Бизнес эрхлэгчид хэрхэн хохирч байгаа талаар бас байнга ярьдаг боловч нэгдсэн судалгаа, үнэлгээ бас хийгддэггүй юм байна. Тийм учраас яг үүн дээр маш системтэй судалгаа, үнэлгээ хийх шаардлагатай юм байна. Тэгээд түүн дээрээ үндэслэж хууль эрх зүйн орчноо сайжруулах хэрэгтэй юм байна.

Тэгээд Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас авсан судалгаагаар хүнд суртлын бизнесүүдэд учирч байгаа индекс 2.72 гэдэг их муу дүн авдаг юм байна. Тэгээд төрийн үйлчилгээ буюу зөвшөөрлийн үйлчилгээ авах болгондоо дандаа зардал гаргадаг гэж.

Тэгээд энэ зардал нь заримдаа хууль бус байдаг. Харамсалтай нь энэ хууль бус гаргасан зардлаа хаанаас яаж олж авах нь тодорхойгүй. Ингээд нөгөө бид нарын дэмжих гээд байдаг бизнес эрхлэгчид маань төрийн буруутай үйл ажиллагаанаас болоод нэмж хохироод байна.

Тэгэхээр Засгийн газрын мөрийн хөтөлбөрт оруулсан энэ ажлаа эхлүүлээч ээ гэдэг ийм л тов тодорхой санал байгаа юм. Тэгэхээр үүнийг оруулаад дэмжээд явбал цаашаа Засгийн газар маань бас ажиллаад эхлэх нь зүйтэй байх гэж бодож байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Ж.Баярмаа гишүүний хоёр дахь зарчмын зөрүүтэй санал мөн түрүүнийхтэй адилхан. Үйл ажиллагааны 4 жилийн хөтөлбөрт туссан 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусаагүй байгаа юм байна.

Тийм учраас Засгийн газрыг шахаж энэ ажлаа бас шуурхайчлах чиглэлээр зарчмын зөрүүтэй саналын томьёолол оруулж байна гэж ойлгож байна.

Ж.Баярмаа гишүүний зарчмын зөрүүтэй саналын томьёололыг уншиж танилцуулсан. Ирц яахаар байна? Санал хураалт. Бүгдээрээ дэмжиж байж санал дэмжигдэх юм байна шүү. 100 хувь дэмжиж байж дэмжигдэнэ.

Анхааралтай бүгдээрээ саналаа өгчихвөл дэмжигдэхээр байна. Санал хураалт. /алх цохив/

Нэг дэх асуудал нь ч их чухал л юм байсан юм. Хоёр дахь асуудал зарчмын зөрүүтэй санал нь 13 гишүүнээс 7 гишүүн дэмжиж 53.8 хувиар дэмжигдлээ.

Дэмжигдсэн саналыг дэмжигдсэн, дэмжигдээгүйгээр нь Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ. Тийм үү? Босгоё гэж үү? Унасан шүү дээ. Сая харин

горимыг нь уначихсан байхгүй юу. Тийм. Харин тийм. Уг нь их чухал асуудал юм байгаа юм шүү дээ.

Тэртээ тэргүй Засгийн газар хийнэ гээд. Та эсвэл санал гаргах уу? Тэгье. Тэгвэл Л.Энх-Амгалан гишүүн горимын санал гаргаж байна.

Л.Энх-Амгалан: Хурал даргалагчид зарчмын зөрүүтэй санал гаргах гэсэн юм. Учир нь өнөөдрийн манай Байнгын хороон дээр санал уншиж байгаа машинуудыг бүгдэд нь бас энэ техникийн тохиргоо хийх шаардлага үүссэн юм шиг байна. Яагаад гэвэл бүх гишүүд дээр одоо яг хуруугаа уншуулахад 7-гоос 8 секунд ерөөсөө хуруу нь уншигдахгүй байж байгаад тэгээд яачхаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр тэр эхний О.Алтангэрэл сайдын гаргасан горимын саналыг одоо дахиж санал хураалгаж өгөөч ээ гэж санал гаргаж байгаа юм.

Ц.Сандаг-Очир: О.Алтангэрэл сайдын гаргасан горимын санал дэмжигдээгүй унасан байгаа учраас О.Алтангэрэл сайдын гаргасан горимын саналыг ахиж дэмжье гэсэн Л.Энх-Амгалан гишүүний гаргасан саналыг санал хураалт явуулъя. /алх цохив/

53 хувиар О.Алтангэрэл сайдын гаргасан горимын саналыг, хүчингүй болгох санал дэмжигдлээ.

Одоо зарчмын зөрүүтэй гаргасан Ж.Баярмаа гишүүний нэг дэх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Гишүүд анхааралтай. Санал хураалт. /алх цохив/

7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ. Баярлалаа гишүүдэд.

Тав дахь асуудал. Одоо удахгүй гишүүд ээ.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ?

Ж.Баярмаа гишүүн өөрөө танилцуулчихъя. Тэгэх үү? Хоёр зарчмын зөрүүтэй саналаа бас хамгаалаад, тайлбарлаад.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа танилцуулна.

Дараагийн асуудалдаа оръё.

**Тав.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль
/Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон
хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд
/Засгийн газар 2025.05.09-ний өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/**

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүд.

Засгийн газар 2025 оны 05 сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Р.Эрдэнэбүрэн сайд байгаа юм уу? Р.Эрдэнэбүрэн сайд байхгүй байна. П.Зоригтбаатар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Бүс, орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын дарга байна. Д.Саруул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга байна. А.Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга байна. М.Үнэнбат Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнүүдийг танилцууллаа.

Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ. Хэрэв төслийн зүйлээр хуульд шинээр бүлэг, дэд бүлэг, нэмэх, бүлэг, дэд бүлгийг бүхэлд нь өөрчлөх бол тухайн бүлгийн зүйл бүрээр хэлэлцэнэ.

Чуулганы дэгийн хуралдааны 39.11-д гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагч болон бусад оролцогчоос асуулт асууж болно гэсэн байна.

Хууль, тогтоолын төслүүдийг зүйл бүрээр хэлэлцье.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Зарчмын зөрүүтэй санал байгаа юу? Зарчмын зөрүүтэй санал байхгүй байна.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Зарчмын зөрүүтэй санал байгаа юу? Байхгүй байна.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагах “Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Тогтоолын төсөлтэй холбогдуулж. Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй санал байхгүй байна.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль Шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Зарчмын зөрүүтэй санал байхгүй.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль Шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Зарчмын зөрүүтэй санал байхгүй.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль Шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

О.Номинчимэг гишүүн горимын санал гаргаж байна. О.Номинчимэг гишүүний микрофон.

О.Номинчимэг: Нэмэлт зарчмын зөрүүтэй санал байхгүй байгаа учраас энэ хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгээр нь эцэслэн батлах горимын санал гаргаж байна.

Ц.Сандаг-Очир: Зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас анхны хэлэлцүүлгийг эцсийн хэлэлцүүлэгтэй хамтран хэлэлцүүлэх горимын санал гаргаж байна.

О.Номинчимэг гишүүний гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

13 гишүүнээс 61.5 хувийн санал дэмжигдлээ.

О.Алтангэрэл гишүүнийг дэмжсэнд тооцоорой. Протокол тохируулаарай.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг танилцуулъя.

Тав дахь асуудал хэлэлцэж дууслаа. Зургаа дахь асуудал.

**Зургаа. “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх тухай”
Улсын Их Хурлын тогтоол**

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх тухай асуудал.

Чөлөөлөх хүсэлтийг нь уншиж танилцуулъя.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны дарга Д.Дэлгэрнаран Танд хүсэлт гаргах нь.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөгдөх тухай Дагвадоржийн Дэлгэрсайхан миний бие 2024 оны 01 сарын 04-ний өдрөөс Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр ажиллаж ирсэн.

Одоо өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт байх тул хуулийн дагуу шийдвэрлүүлж өгнө үү.

Хүсэлт гаргасан Д.Дэлгэрсайхан гэсэн байна.

2025 оны 04 сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд гээд ирүүлсэн юм байна. Ийм хүсэлтээ ирүүлсэн байна.

Ийм хүсэлт ирсэн учраас Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 6.3-ын хорооны гишүүн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан бол Улсын Их Хурал энэ хуулийн 4.2-т заасан хугацаанаас өмнө түүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлнө гэж заасан байдаг юм байна.

Мөн Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 6.6-д хорооны гишүүн огцрох тухай хүсэлтээ Улсын Их Хуралд бичгээр гаргаж болох бөгөөд уг хүсэлтийг Улсын Их Хурлын чуулганы үед гаргасан бол 21 хоногийн дотор, чуулганы чөлөөт цагт гаргасан бол чуулган эхэлснээс хойш 21 хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэж шийдвэрлэнэ гэсэн ийм заалттай юм байна.

Хүсэлтийг уншиж танилцууллаа. Хуулийн тайлбарыг танилцууллаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Г.Уянгахишиг гишүүн асуулт асууя гэж байна. Хэнээс асуух юм? Энэ чинь одоо өргөдөл гаргасан хүн нь байгаа юм уу? Юу ч гэсэн юм. Та асуултаа асуудаа.

Г.Уянгахишиг: Одоо наана чинь өргөдөл нь ирсэн байгаа байх.

Тэгээд ер нь зүгээр ерөнхийд нь асуух гэсэн юм. Одоо Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөгдөхөөр яг одоо бүрэн гишүүнтэй байж байгаа юу? Тэгээд нэг гишүүн дутах болж байгаа юу? Тэгээд ер нь мэдээж нэг гишүүн чөлөөлөгдөхөөр дараагийн орны хүнийг сонгох ёстой шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр ер нь энэ чинь яадаг юм? Яаралтайгаар орж ирээд чөлөөлөхөөр нөгөө сул орон тоо үүсчхээд байдаг. Тэр нь одоо жишээлбэл дараагийн цаашаагаа Сонгуулийн ерөнхий хорооны ажил хийгдэх дээр асуудал дээр асуудал үүсэх үү, үгүй юу? Энэ дараагийн гишүүнийг хэзээ, яаж оруулж ирэх юм болоо? Тэр талаар.

Ц.Сандаг-Очир: Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийнхаа хүрээнд орон гарсан гишүүний орны асуудлыг манай Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд оруулж ирнэ.

Тийм учраас одоо хүсэлтээр нь чөлөөлсөн тохиолдолд дараагийн ээлжид Төрийн байгуулалтын байнгын хороо нэн даруй дараагийн гишүүний асуудлыг нэр дэвшүүлж оруулж ирэх асуудал яригдах юм байна.

Нэг л гишүүн. Нэг л гишүүний асуудал. Орон гарсан. Чөлөөлөгдсөн учраас. Ингээд Төрийн байгуулалтын байнгын хороогоор дараагийн нэр дэвшигчийн асуудлыг оруулж ирж хуулийн хүрээнд шийдвэрлэнэ гээд ийм байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Дагвадоржийн Дэлгэрсайханыг өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд ээ, санал хураалт. /алх цохив/

Хөөе. Гаргахгүй болгож байна уу, үгүй юу? Б.Баярбаатар гишүүн горимын санал.

Б.Баярбаатар: Энэ санал хураах машин маань алдаа заагаад улаан асчихлаа.

Тэгэхээр саяын саналыг хүчингүй болгож өгөх горимын санал гаргаж байна.

Ц.Сандаг-Очир: Б.Баярбаатар гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя.

Юу вэ? Г.Уянгахишиг гишүүн эд нар эсрэг гараад байна шүү дээ. Г.Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Сая төхөөрөмж алдаа заалаа. Тэгээд одоо энэ яг ганцхан саналын зөрүүгээр асуудал шийдэгдээд байгаа учраас дахин санал хураалт явуулах горимын санал гаргаж байна.

Ц.Сандаг-Очир: Г.Уянгахишиг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Хүчингүй болгох санал хураалт 61.5 хувиар дэмжигдлээ.

Г.Уянгахишиг гишүүнийг дэмжсэнд тооцоорой.

Ингээд санал хураалт санал хураалтыг Дагвадоржийн Дэлгэрсайханыг өөрийнх нь гаргасан хүсэлтийн дагуу Сонгуулийн ерөнхий хорооноос чөлөөлөх тухай томьёоллоор санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт. /алх цохив/

9 гишүүн дэмжиж, 69.2 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье.

Хуралдаандаа идэвхтэй оролцсон Ж.Баярмаа, Г.Уянгахишиг гишүүн, С.Бямбацогт, Л.Энх-Амгалан, О.Алтангэрэл, Э.Болормаа, Б.Баярбаатар гишүүндээ талархал илэрхийлье.

Хуралдаан 1 цаг 52 минут үргэлжилж, 13 цаг 28 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД